



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2017.09.19, МЯГМАР ~ №177 (723)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 600Т

Ерөнхийлөгч НҮБ-ын Ерөнхий ассамблейд оролцохгүй

Сүүлийн долоон жил дараалан оролцсон Төрийн тэргүүний буухиа тасарч байна. > 2

Шуурга сөрсөн тэрбумтнууд

Samsung Electronics-ийн хувьцааны ханш жилийн хугацаанд 60 гаруй хувиар өссөн. > 6

FT ■ Бангладеш рохинжа нарын хөдөлгөөнийг хязгаарлав

FINANCIAL TIMES ■ WTI фьючерс Brent-ийг гүйцлээ

Ubinfo.mn сайт шилдэгт багтлаа

"Засгийн газрын мэдээ" сонины цахим хуудас Ubinfo.mn нь Монголын мэдээллийн шилдэг сайтуудын зургадугаарт бичигдлээ.

- Gogo.mn
- lkon.mn
- Xopom.com
- Caak.mn
- Zaluu.com
- Ubinfo.mn
- Medee.mn
- News.mn
- Biznetwork.mn
- View.mn

Эх сурвалж: Alexa.com©

ОНЦЛОХ

- УЛС ТӨР**
Ерөнхийлөгч Х.Баттулгад Канадын Элчин сайд итгэмжлэх жуух бичиг барив.
Ц.Мөнх-Оргил НҮБ-ын Ерөнхий ассамблейн санал шүүмжлэлд оролцоно.
Засгийн газар аймгуудын ЗДТГ-ын дарга нарт чиглэл өгөв.
Ерөнхийлөгчийн албан бичигт УИХ-ын Тамгын газар хариу өгөөгүй байна.
Цэвэрлэх байгууламжийг Японы технологиор барих хүсэлт илэрхийлэв.
- ЭДИЙН ЗАСАГ**
Монголын хөрөнгийн зэх зээлийн үнэлгээ хоёр их наяд төгрөг давлаа.
ББСБ-ын нийт актив энэ оны хоёрдугаар улиралд 855.8 тэрбум төгрөгт хүрчээ.
Сэлэнгэ мөрөнд гүүр барьж, ургац тээвэрлэх замыг дөт болголоо.
Төмөр замын тээврийн орлого 65 тэрбум төгрөгөөр өсөж, 339 тэрбум төгрөгтэй тэнцэв.
Хятадад өнгөрсөн сард орон сууцны үнийн өсөлт саарчээ.
- НИЙГЭМ**
Монгол, Японы эрдэмтэд 50 гаруй дурсгалыг судалгаанд оруулжээ.
Ирэх баасан гарагаас ихэнх нутгаар хүйтэрийг ЦУОШГ анхаарууллаа.
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам 80 хүүхдийн цэцэрлэгтэй боллоо.
Багш нар энэ сарын 21, 26-нд сануулах ажил хаялт улсын хэмжээнд зохион байгуулна.
"Намрын ногоон өдрүүд-2017" үзэсгэлэн худалдаа "Мишээл экспо"-д нээлтээ хийлээ.
- ДЭЛХИЙ**
Сирийн босогчдыг ОХУ бөмбөгдсөн гэх мэдээллийг Москва няцаалаа.
Өмнөд Солонгос, АНУ аравдугаар сард хамтарсан сургуулилалт явуулна.
Их Британи террорист аюул заналтай холбоотой бэлэн байдлын түвшингөө бууруулав.
Хятадын ачаа тээврийн хөлөг анх удаа сансрын станцтай амжилттай залгагдлаа.
Японд зуугаас дээш настай 67824 хүн аж төрж байгаа нь шинэ амжилт тогтоов.

Шүлхийн голомт хяналтаас гарлаа



Жил бүр олон тэрбум төгрөгөөр малын гоц халдварт өвчний вакцин худалдаж авдаг ч газар нутгийн тэн хагас шүлхийд дарлуулж, шүлсээ гоожуулсан салаа туурайтнаар дүүрэх нь. ▶3

ЗГМ: СЭДЭВ

Очих газраа олно гэдэг "оньсого" таахтай адил

Г.Оюунтөгс
@oyuntugsZGM

“Сөүлийн гудамж” гэх мэт нийт 164 хаяг байдаг боловч яг энэ нэрээр нь асууж сураглавал мэдэх хүн үнэхээр олддоггүй юм байна. Дуудлагаар хүргэлт болон нүүлгэлтийн үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгжүүдийн хэлж буйгаар очих газраа бараг хагас цаг орчим хайсны эцэст олдог байна. Зарим үед машин орох боломжгүй мухар газар ч олон тааралддаг аж.

Тэгвэл 2013 онд Улаанбаатар хотыг олон улсын стандартад нийцсэн хаягжуулалтын нэгдсэн системтэй болгох төслийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас эхлүүлжээ.

ЭДИЙН ЗАСАГ

Төсөөллөөс давсан нэг их наяд

Г.Байгал
@baigalZGM

Төсвийн орлого төсөөллөөс давлаа. Төлөвлөснөөс ойролцоогоор их наяд төгрөгөөр илүү бүрдсэн таатай мэдээг Үндэсний статистикийн хороо мэдээлэв. Тодруулбал, энэ оны эхний найман сарын байдлаар төсвийн орлого 904 тэрбум төгрөгөөр давж, биелжээ. Уг нь 3.5 гаруй их наяд төгрөгт хүрнэ хэмээн таамаглаж байсан төсвийн орлого даруй тэлж, 4.5 наяд төгрөг даваад байна. Төсөвийнхүү таамагас талийхад татварын орлого “тусалжээ”. Нийт орлогын 80 хувийг бүрдүүлдэг татварын орлого 763 тэрбум төгрөгөөр өссөн.

СОНИНЫ ФОРУМ 2017

ӨДӨР ТУТМЫН СОНИНЫ АНХДУГААР ФОРУМ

2017 ОНЫ 9 ДҮГЭЭР САРЫН 21, 09:00 ЦАГТ БЛЮ СКАЙ ТАУЭР, 2 ДАВХАР, "DIAMOND" ТАНХИМ

ОДРИЙН СОНИН | ӨНӨӨДӨР | ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИН | FT | Өмнөд Солонгос

СЭС ТӨРИЙН | МЭДЭЭ | ТАСВИЙН ШУУДАН | МОНГОЛЫН МЭДЭЭ | М

МОНГОЛЫН ҮНЭН | АРДЧИЛАЛ | ӨНГӨСӨЙН ХЭТЭЭ

MSE ALL 1050.23 2.2%	АЛТ 1314.46 0.43%	ЗЭС 6507 0.14%	10-ЧИНГИС БОНД 97.450 0.03%	5-ЧИНГИС БОНД 100.51 0.01%	АМ.ДОЛЛАР 2465.03	ЮАНЬ 376.39	РУБЛЬ 42.77
-----------------------------------	--------------------------------	-----------------------------	------------------------------------------	-----------------------------------------	-----------------------------	-----------------------	-----------------------

Улс төр

АЙЛЧЛАЛ

Ерөнхийлөгч НҮБ-ын Ерөнхий ассамблейд оролцохгүй

НҮБ-ыг хэд хэдэн удаа шүүмжилж байсан Дональд Трамп энэ чуулганаар олон улс, ялангуяа БНАСАУ-ын талаар ямар мэдэгдэл хийх нь дэлхий нийтийн анхаарлын төвд байна.



Сүүлийн долоон жил дараалан оролцсон Төрийн тэргүүний буухиа тасарч байна

Б.Даваатогтох
@datoZGM

Дэлхийн 197 орны төр, засгийн тэргүүн нар жилд нэг удаа цугларч, үзэл бодол, байр сууриа харилцан солилцох хамгийн том механизм нь НҮБ-ын Ерөнхий ассамблей. Тэгвэл Ерөнхий ассамблейн 72 дахь удаагийн чуулган өнөөдөр АНУ-ын Нью-Йорк хотноо эхлэх гэж байна. “Хүмүүст төвлөрөх нь: Тогтвортой хөгжил бүхий ертөнцөд энх тайван, сайн сайхан амьдралыг цогцлох нь” уриан дор зохион байгуулагдах энэ удаагийн чуулганд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга оролцохгүй гэдгийг Гадаад харилцааны яамнаас мэдэгдлээ. Ингэснээр НҮБ-ын Ерөнхий ассамблейн чуулганд сүүлийн долоон жил дараалан оролцсон Монгол Улсын Төрийн тэргүүний буухиа тасарч байна. Харин Гадаад харилцааны сайдын үүрэг гүйцэтгэгч Ц.Мөнх-

Оргил Ерөнхий ассамблейн 72 дугаар чуулганы ерөнхий санал шүүмжлэлд оролцож, олон улсын харилцааны тулгамдсан асуудлаар Монгол Улсын байр суурийг илэрхийлж, үг хэлнэ. Мөн төр, засгаас хэрэгжүүлж буй гадаад бодлогын зорилт, тэргүүлэх чиглэл, нийгэм, эдийн засгийн салбарт хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаагаа танилцуулах аж. Гадаад харилцааны сайдын үүрэг гүйцэтгэгч Ц.Мөнх-Оргил чуулганы үеэр болох Далайд гарцгүй хөгжиж буй орнуудын сайд нарын уулзалт, Хөгжиж буй

орнуудын 77-гийн бүлгийн сайд нарын уулзалтад оролцохоор төлөвлөжээ. Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын Олон улсын судалгааны төвийг Улаанбаатар хотноо байгуулах хэлэлцээрийг ирэх сарын 6-нд албажуулахаар болсон юм. Ингэснээр олон улсын Засгийн газар хоорондын анхны төв Улаанбаатарт байгуулагдана гэсэн үг. Далайд гарцгүй хөгжиж байгаа орнуудын өмнө тулгарч байгаа хүндрэл бэрхшээлийг тодорхойлж, түүнээс гарах арга замыг эрэлхийлж, бодлогын

зөвлөмж өгөх чиг үүрэгтэй байгууллага юм. Үүнээс гадна Цөмийн туршилтыг бүрэн хориглох гэрээг хүчин төгөлдөр болгоход дэмжлэг үзүүлэх бага хуралд оролцохын зэрэгцээ Эвсэлд үл нэгдэх хөдөлгөөний сайд нарын уулзалт болон Азид хамтын ажиллагаа, итгэлцлийг бэхжүүлэх бага хурлын гишүүн орнуудын сайд нарын албан бус уулзалтад оролцож, байр сууриа илэрхийлэх аж. Түүнчлэн Литва, Румын, Канад улсын Гадаад хэргийн сайд болон АНЭУ-ын Төрийн сайдтай хоёр талын уулзалт хийж, харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцоно.

Энэ удаагийн Ерөнхий ассамблейн 72 дугаар чуулганаар олон улсын анхаарлын төвд ороод буй Солонгосын хойгийн асуудлыг голчлон хэлэлцэхээр төлөвлөжээ. Мөн уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээр болон хямрал болтлоо гүнзгийрсэн рохинжа нарын асуудлыг хөндөх хүлээлт байгаа юм. Энэ удаагийн чуулганд АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп оролцоно. НҮБ-ын талаар хэд хэдэн удаа шүүмжлэлтэй байр суурь илэрхийлж байсан тэрбээр энэ чуулганаар олон улс, ялангуяа, БНАСАУ-ын талаар ямар мэдэгдэл хийх нь дэлхий нийтийн анхаарлын төвд байгаа

● **Гадаад харилцааны сайдын үүрэг гүйцэтгэгч Ц.Мөнх-Оргил Ерөнхий ассамблейн 72 дугаар чуулганд оролцоно.**

● **Олон улсын анхаарлын төвд ороод буй Солонгосын хойгийн асуудлыг голчлон хэлэлцэхээр төлөвлөжээ.**

● **ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин хоёр дахь удаагаа өнжихөөр болжээ.**

юм. “Reuters” агентлагийн мэдээлснээр Ерөнхий ассамблейн 72 дугаар чуулган эхлэхийн өмнө АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп бусад улс орны тэргүүн нартай хоёр талын уулзалт хийж, НҮБ-д бүтцийн өөрчлөлт хийх асуудлыг хөндөх аж. Тэрбээр НҮБ-ын ажилтнуудын тоог цөөлөх, АНУ-д ногддог татварын хэмжээг бууруулах санаачилга гаргажээ. Харин ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин хоёр дахь удаагаа өнжихөөр болсон байна. Тус улсын багийг Гадаад хэргийн сайд С.Лавров тэргүүлнэ. Мөн Мьянмарын Гадаад хэргийн сайд Аун Сан Су Чи ч Ерөнхий ассамблейд оролцох төлөвлөгөөгөө цуцалжээ. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» **ЕРӨНХИЙЛӨГЧ**
Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга Канад улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дэвид Спрел итгэмжлэх жуух бичиг барив. Ерөнхийлөгч Х.Баттулга Канад бол уул уурхайн орон гэдгийг онцлоод ялангуяа, нөхөн сэргээлт хийх туршлагатай улс гэдгийг онцлов. Байгаль орчныг нөхөн сэргээхээр хамтран ажиллах сонирхолоо илэрхийллээ. Мөн хоёр талын худалдааны эргэлт чамлалттай хэмжээнд байгааг дурдав.

» **ЗАСГИЙН ГАЗАР**
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга У.Бямбасүрэн аймгуудын Засаг даргын Тамгын газрын дарга нартай уулзаж, өвөлжилтийн бэлтгэл ажил, ургац хураалтын явц, цаг үеийн асуудлын талаар хэлэлцэв. Санаачлагатай, ажилдаа эзэн бол ажиллахыг төрийн албан хаагч нэг бүрээс шаардаж байх, байгууллагдаа дотоод сургалтыг тасралтгүй явуулж байхын чухлыг тэрбээр чиглэл болголоо.

» **ТОО**

63

Хэлэлцүүлэг. Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийг 21 аймаг, нийслэлийн есөн дүүрэгт нийт 63 удаа зохион байгуулж, 239600 санал ирсэн байна. Хэлэлцүүлэг зохион байгуулах ажилд төрийн 4705 албан хаагч, 12797 иргэн оролцжээ.

» **АЛБАН БИЧИГ**

Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга УИХ-ын ээлжит бус чуулганыг энэ сарын 18-22-ны өдрүүдэд зарлан хуралдуулахыг хүссэн албан бичгийг өнгөрсөн баасан гарагт УИХ-ын дарга М.Энхболдод хүргүүлсэн билээ. Харин энэхүү албан бичигт УИХ-ын Тамгын газраас хариу өгөөгүй байгааг Ерөнхийлөгчийн Тамгын газраас онцлов.

ТОДРУУЛГА & ЗАЛРУУЛГА

Уншигч та манай сонин мэдээ, нийтлэл, сурвалжилгатай холбоотой тодруулж, залруулах шаардлагатай санал, хүсэлт байвал

» OPED@ZASAG.CO

Утас: 99903584 хаягаар бидэнтэй холбогдоно уу.

НҮБ, ТҮҮНИЙ СИСТЕМИЙН БАЙГУУЛЛАГУУДААС МОНГОЛ УЛСАД ӨГСӨН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ

1963-2003	260
2002-2006	78.2
2007-2011	40
2012-2015	74.3

(сая ам.доллар)

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА

СЭТГҮҮЛЧ:

Эдийн засаг, уул уурхай, улс төрөөр дагнан мэдээ, мэдээлэл нийтлэн уншигчдад хүргэдэг ЗГМСонин ХМХ нь Сэтгүүлч таныг ажилд урьж байна.

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Уул уурхай, эдийн засаг, бизнесийн салбарын мэдээллийг төлөвлөж, эрэл хайгуул хийж боловсруулж, төлөвлөсөн хугацаанд багтан нийтлэл бичих чадвартай байх,
- Мэдээний эх сурвалжид үндэслэн цаг үеийн мэдрэмжтэй, сэтгүүлзүйн шаардлагуудыг хангасан нийтлэл бэлдэх,
- Нийгэмд шаардагдаж буй өнцгөөс харж нийтлэлүүд бичих, цаг үеийн байдлыг оновчтойгоор сурвалжлах,
- Эдийн засаг, уул уурхайн чиглэлээр мэдлэгтэй байх.

АЖИЛ ГОРИЛОГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Цаг хугацааны хувьд давчуу, ажлын ачаалал ихтэй орчинд ачаалал дааж ажиллах чадвартай байх,
- Уул уурхайн болон бизнесийн чиглэлээр сэтгүүл зүйн бүтээл туурвиж байсан туршлагатай байх,
- Багийн гишүүн байж, бусадтай үр дүнтэй хамтран ажиллах чадвартай байх,
- Хурдан, алдаагүй бичиж шивдэг байх,
- Төлөвлөлт болон бэлтгэл ажлыг оновчтой хийдэг байх,
- Англи болон Орос хэлийг эзэмшсэн бол давуу тал болно,
- Холбогдох чиглэлийн Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, эсвэл ажлын туршлагатай.
- Хэрвээ та өөрийгөө дээрх ажлын байранд нийцэх боловсон хүчин гэж үзэж байгаа бол Англи болон Монгол хэлээр бэлтгэсэн CV-гээ бидэн рүү доорх хаягаар ирүүлээрэй. Бид тантай холбогдож дараагийн алхамуудыг хэлэлцэх болно.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

Ажилд орохыг хүссэн өргөдөл, анкет, гурван үеийн намтар, ерөнхий боловсролын гэрчилгээ, их, дээд сургуулийн диплом болон мэргэжлийн, үнэмлэхийн хуулбарыг нотариатаар баталгаажуулсан байх, 2 хувь цээж зураг (сүүлийн 3 сарын дотор авахуулсан), оршин суугаа хаягийн тодорхойлолт, өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт.



Ажилд орохыг хүссэн анкет
“Засгийн газрын мэдээ сонин” ХМХ-ийн байранд ирж бөглөх ба Dulamkhorloo.b@zasag.co, Baasan.b@zasag.co и-мэйл хаягт илгээж болно.
Бүрдүүлэх материалын мэдээллийг 70103131 утсаар лавлана уу.

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА

ЦАХИМ СЭТГҮҮЛЧ:

Эдийн засаг, уул уурхай, улс төрөөр дагнан мэдээ, мэдээлэл нийтлэн уншигчдад хүргэдэг ЗГМСонин ХМХ нь цахим хэвлэл мэдээлэл /Контент/ харуусан Сэтгүүлч таныг ажилд урьж байна.

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Сонинд нийтлэгдсэн мэдээ, нийтлэлийг цаг алдалгүй цахим хэлбэрт шилжүүлэн бүтээлчээр нийтлэх.
- Мэдээллийг оновчтой гарчиглан уншигчдад үнэн зөв, алдаагүй хүргэх.
- Нийгмийн сүлжээний хуудсуудыг идэвхжүүлэх, хөгжүүлэх.
- Мэдээний эх сурвалжид үндэслэн нийтлэлийг зурагжуулах, дүржүүлэх үзэгдэх байдлыг баяжуулах.
- Уншигчдад сэтгэгдэл төрүүлэхүйц мэдээллийг сонгох.

АЖИЛ ГОРИЛОГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Цаг хугацааны хувьд давчуу, ажлын ачаалал ихтэй орчинд ачаалал дааж ажиллах чадвартай байх,
- Социал орчинд бүтээлчээр ажилладаг байх, технологийн шинэ дэвшилүүд, шинэ бүтээгдэхүүнүүдэд мэдрэг байж, санаачлагатай ажиллах,
- Эдийн засаг, Уул уурхай болон бизнесийн салбарын сэтгүүл зүйн туршлага, мэдлэг ойлголттой байх,
- Хурдан, алдаагүй бичиж шивдэг байх,
- Төлөвлөлт болон бэлтгэл ажлыг оновчтой хийдэг байх,
- Англи болон Орос хэлийг эзэмшсэн бол давуу тал болно,
- Холбогдох чиглэлийн Бакалавр, эсвэл түүнээс дээш зэрэгтэй, ажлын туршлагатай байх.
- Хэрвээ та өөрийгөө дээрх ажлын байранд нийцэх боловсон хүчин гэж үзэж байгаа бол Англи болон Монгол хэлээр бэлтгэсэн CV-гээ бидэн рүү доорх хаягаар ирүүлээрэй. Бид тантай холбогдож дараагийн алхамуудыг хэлэлцэх болно.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

Ажилд орохыг хүссэн өргөдөл, анкет, гурван үеийн намтар, ерөнхий боловсролын гэрчилгээ, их, дээд сургуулийн диплом болон мэргэжлийн, үнэмлэхийн хуулбарыг нотариатаар баталгаажуулсан байх, 2 хувь цээж зураг (сүүлийн 3 сарын дотор авахуулсан), оршин суугаа хаягийн тодорхойлолт, өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт.



Ажилд орохыг хүссэн анкет
“Засгийн газрын мэдээ сонин” ХМХ-ийн байранд ирж бөглөх ба Dulamkhorloo.b@zasag.co, Baasan.b@zasag.co и-мэйл хаягт илгээж болно.
Бүрдүүлэх материалын мэдээллийг 70103131 утсаар лавлана уу.

Нийтлэлчийн булан

6800 орчим мал шүлхийгээр өвдсөнөөс 90 гаруй хувийг нь устгажээ

З.Цэлмэг
@tselmegZGM

Монголын газар нутгийн тэн хагас шүлхийд дарлуулж, шүлсээ гоожуулсан салаа туурайтнаар дүүрэх нь. Экспортын хориотой гоц халдварт өвчин болох шүлхийн вирус зүүнээс баруун зүгт их нүүдэл хийж байна уу гэлтэй энэ жил төвийн бүс, нийслэл орчим шүлхийн идэвхтэй голомт болж хувирлаа.

Уг нь төвийн 10 аймаг малын гаралтай түүхий эдээ экспортлодог тул вакцингүй бүс байх ёстой. Харамсалтай нь энэ жил шүлхийн голомтын хүрээ төвийн бүсэд тархсанаас Монгол орны тэн хагас нь гоц халдвартай бүс нутаг болоод буй. “Нийслэлийг шүлхий бараг л нөмөрчихлөө” хэмээн халаглахад “Нийслэлээр ч тогтохгүй боллоо” хэмээн салбар яам болон мэргэжлийн байгууллагын ажилтнууд хариулж байгааг бодоход манай улс шүлхийн голомтыг хяналтаасаа алдсан бололтой. Мал эмнэлгийн хүрээлэнгийн Халдварт өвчин, дархлаа судлалын лабораторийн эрхлэгч Ж.Эрдэнэбаатар одоогийн нөхцөл байдлыг гамшигтай зүйрлэж орхив.

Малын эрүүл мэндийн цаана хүний эрүүл мэнд яригддаг учир Монголын төр малын эрүүл мэндээ орхигдуулж байгаагүй. Тиймээс л 1974-2000 он хүртэл шүлхий болон малын бусад төрлийн халдварт өвчин гараагүй аж. Мал эмнэлгийн нэгдсэн бодлого, босоо удирдлагын тогтолцоо хэрэгждэг байсан учир монголчууд малын өвчнөө дарж, эрүүл мах хүнсэндээ хэрэглэдэг байсан талаар Хөдөө аж ахуйн академийн ерөнхийлөгч Б.Бямбаа ярьсан.

Харамсалтай нь, өнгөрсөн зуунд дарж чадсан цэцэг, боом, шүлхий, мялзан гээд малын буян арилмаар олон гоц халдварт өвчин сүүлийн жилүүдэд сэргэв. Энэ нь нэг талаар дэлхий даяар дээрх бүх өвчний дахин дэгдэлт болж буйтай холбоотой аж. Өнөөдөр дэлхий дээр байгаа өвчнүүдийн 75 хувь нь мал, амьтнаас хүнд халддаг. Жил бүр нэг шинэ өвчин бүртгэгдэж байгаа талаар Ж.Эрдэнэбаатар хэлж байсан. Тухайлбал, 1940-2002 онд 335 шинэ өвчин бүртгэгдсэний 85 хувь нь хүнд халддаг байна. Түүнчлэн малын өвчний вирус маш хурдтай хувьсаж, мутацид орж байгаа нь вакцины үйлчлэл саарах, цаашлаад ямар төрлийн



С.Батсайхан / ЗГМ©


Аймаг, сум, баг бүр малын эмчтэй, бүх л бүтэн бодлого хариуцсан яамтай, эрдэм шинжилгээний байгууллагад нь олон зуун эрдэмтэн ажилладаг мал эмнэлгийн салбар өнөөдөр 61 сая малынхаа эрүүл мэндийг хамгаалж чадахгүй байна.

хамрагдана гэсэн ойлголт байхгүй. Албадан хамруулах ёстой хуулийн заалт байдаг аж. Гэтэл малчин, малын эмчийн хэн хэн нь ноцтой асуудалд хариуцлагагүй хандсан нь угтаа бол мал эмнэлгийн салбарын төрийн бодлого алдагдсаны нэгэн жишээ.

Гэтэл хорио цээртэй энэ бүсэд ариутгал, халдваргүйжүүлэлт хийж байгаа нь ч бас нэр төдийхөн. Уг нь 22-ын товчооноос цааш Төв аймгийн Баянчандмань сум хүртэлх замд ариутгалын гурван ч цэг ажиллуулж буй. Эдгээр цэг дээр өнгөрсөн амралтын өдрүүдэд автомашины гадна талыг бүхэлд нь байтугай, дугуйг нь ч ариутгахгүй байна. Нойтон эсгий дээгүүр гаргах төдийхөөр нийслэлийн бүс дэх хорио цээрийн ажил үргэлжилж байгааг зориуд шүүмжилмээр байна. “Онцгой байдлын ерөнхий газар, мэргэжлийн хяналтын байгууллага засаг даргын гаргасан захирамжийн биедлэгийг хангаж ажиллах ёстой. Түүнээс яам хяналт шалгалт хийх эрх зүйн үндэс байхгүй” хэмээн С.Батхуяг учирлалаа.

Гэтэл Төв Азид өргөн тархсан мал, амьтны халдварт өвчнөөс сэргийлэхийн тулд ОХУ Монголын хил дагуух бүсээ вакцинжуулаад урьдчилан сэргийллээ. Хятад ч мөн олон зуун сая малаа вакцинжуулаад байгаа аж. Харин бид энд вакцины чанар, тендерийн шахаа тойрсон маргаан төдийгөөр хүн, малын эрүүл мэндээ яаж хамгаалах уу гэх мэтчилэн толгойгоо гашилгаж сууцгаана. Үнэхээр “ухаангүй ноён урагшгүй албаг” гэдэг шиг зүйл зөвхөн манай улсад л тохиолдох юм.

Шүлхийн голомт хяналтаас гарлаа



вирус болохыг нь оношуулж, тогтоохын тулд хугацаа алдахад хүрч буй.

Гэхдээ хаяанд ирсэн аюулыг урьдчилж хараагүй, сонор сэрэмж алдсан, урьдчилан сэргийлэх ажлаа хангалгүй хийж байгааг зөвтгөх хүн үгүй биз. Нэгэнт ороод ирсэн өвчнийг дарах гэж олон тэрбум төгрөгийг татвар төлөгчдийн мөнгөнөөс гаргаж байна. Энэ

онд л гэхэд 3-4 тэрбум төгрөг шүлхийн вакцин худалдаж авах, вакцинжуулалтын үйлчилгээ үзүүлэхэд улсын төсвөөс гаргасан. Өнгөрсөн жил ч мөн төдий тооны мөнгийг малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэхэд зарцуулсан. Он гарсаар нийт 6800 орчим мал шүлхийгээр өвдсөнөөс буюу 90 гаруй хувийг нь устгаад байгааг албаны эх

сурвалж хэллээ.

Жил бүр 150 малын эмч бэлтгэгдэж, аймаг, сум, баг бүр малын эмчтэй, бүх л бүтэн бодлого хариуцсан яамтай, эрдэм шинжилгээний байгууллагад нь олон зуун эрдэмтэн ажилладаг мал эмнэлгийн салбар өнөөдөр 61 сая малынхаа эрүүл мэндийг огтхон ч хамгаалж чадахгүй байна. Цаашлаад 3.1 сая хүний эрүүл мэнд эрсдэлд орж,

монгол малын мах худалдан авч болохгүй гэсэн мессежийг дэлхий дахинд өгч буй.

Шүлхийг яагаад одоо хүртэл дарж чадахгүй байна гэсэн асуултад Мал эмнэлгийн хүрээлэнгийн захирлаар олон жил ажилласан Я.Ганболд доктор “Мал эмнэлгийн өнөөгийн тогтолцоогоор гоц халдварт өвчинтэй тэмцэх боломжгүй. Малчид мал эмнэлгийн арга хэмжээнд оролцдоггүй, мэддэггүй, мэдсэн ч тоологдгүй, энэ чиглэлийн нэгдсэн бодлого байхгүй. Ямар хэвшлээр шүлхий үүсгэгдэж, хэзээ гарах, хаанаас халдвар ирэхийг тандаж судлахгүй байна. 1998 онд мал эмнэлгийг хувьчилсны улмаас төрөөс баримтлах мал эмнэлгийн бодлого алдагдаж, ийм үйлчилгээ байхгүй болсон” гэв. Үүний улмаас олон төрлийн шинэ болон хуучин өвчин Монголд орж ирэх үүд хаалга нээгдэж, мал өвчилж, бид бархирч суугаа аж.

Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 22 дугаар хорооны нутаг дэвсгэр болох Тахилтад гарсан шүлхийн голомт ч малчны хариуцлагагүйн улмаас гарч, хөл хорио тогтоогоод буй. Уг нь малын эмч хоёр ч удаа вакцин хийхээр очсон аж. Эхний удаад согтуу байсан, дараа нь малдаа вакцин хийлгэхээс өөрийн биеэр татгалзсан талаар Мал эмнэлэг, үржлийн газрын гоц халдварт өвчний асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн С.Батхуяг ярьсан. Уг нь гоц халдварт өвчний эсрэг арга хэмжээнд сайн дураараа

Мал эмнэлгийн хазгай бүтэц хаяанд тулсан аюулыг гэтэлж чадахгүй

Цаашдаа тэгээд яах юм бэ. Мал нь өвчиндөө баригдсан, иргэд нь халуурсан малын хүрэн улаан мах худалдаж аваад, яам, агентлагууд нь хэрүүлээ хийгээд суух уу! Эсвэл өвчин үүсгэгч, дамжуулагч, өвчлөмтгий мал гэсэн халдварын гинжин хэлхээг тасалж, мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг хорьж, малчид, малын эмч, салбарын хариуцлагыг дээшлүүлэх ёстой юу. Вакцин тойрсон хэрүүл хийж суухаар лабораторийн хүчин чадлаа дээшлүүлж, өнгөрсөн чуулганаар баталж чадаагүй хоёр хуулиа зүтгүүлбэл хүнсний аюулгүй байдлыг хангахад маш том дэвшил гарах учиртайг мэдэхийн дээдээр мэдэж байгаа биз ээ. [ЗГМ]


ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИН FINANCIAL TIMES UBinfo.mn

ЧИМЭЭ ШУУГЛАН БУС ЗӨВХӨН ЧУХАЛ МЭДЭЭЛЭЛ

Хэвлэмэл захиалга улиралд 30,000₮
Улирлын цахим захиалга өрдөө 5000₮
tdbpay үйлчилгээгээр цахим сонин худалдан авахдаа Та доорх QR кодыг уншуулан гүйлгээний утга хэсэгт өөрийн и-мэйл хаяг, утасны дугаараа бүртгүүлэн дижитал сонинг захиална уу? Таны эрх ажлын 8 цагийн дотор идэвхжих болно.



Утас: 70103131



Судлаачийн үг



Монголтой эртнээс холбоотой тэр нэгэн жижиг атлаа түүхэн үндэстний тухай

Олхонуд Баярхүү
Судлаач профессор

“Цастын орон” буюу “Дэлхийн дээвэр” хэмээн эртнээс алдаршсан, манай Монголтой бол шарын шашин, Дахүрээ-Хөхнуур-Лхасын маршрутын мөргөлчид, үе үеийн Далай ламууд ба Монголын 9 Богдоор холбогдсон тэр нэгэн жижиг атлаа түүхэн үндэстний тухай сэдэв.

XX зууны эхээр шахуу Төв Азийн геополитикийн их орон зайг Оросын геополитикийн судлаач А.Е.Снесарев томъёолохдоо, Туркестан, Шинжаан, Энэтхэг, Афганистан, Иран, Төвөдийг оруулан, түүнийгээ “Дэлхийн бодлогын түлхүүр” гэж нэрлэжээ. Шинжаан, Төвөд хоёр салшгүй хүйн холбоотой, учир нь энэ хоёр нутгаар дамжин Хятад нь Өмнөд Ази, Дундад болон Зүүн өмнөд Азид нэгэн зэрэг байршиж ирсэн. Нөгөө талаас Төв Азиас Зүүн өмнөд Ази руу нэвтрэх гарц ганцхан эндхээр дамждаг. Хэрэв Шинжааныг газар зүйн нэг тойрог гэж үзвэл, түүний салаа мөчрүүд Азийн аль ч өнцөг рүү тархаж болох учраас Америкийн нэрт эрдэмтэн З.Бжезинский эндхийн газрыг “цүлхэн” (анклав) гэж нэрлэсэн удаа бас бий. Евразийн их уулс өөр хоорондоо даваа гүвээ, нуруудаар холбогдсон байдаг, тогтоцоор нь авч үзвэл уулс нь хаяа хүрээгээ тэлсээр ирсэн. Энэ утгаар Хэнтий, Хангай, Монгол Алтай нь барууншаа Тянь-Шань, Памиртай хил нийлэх бөгөөд зүүн урагшаа эргээд Хималайн уулстай залгадаг. Эдгээр уулсын дагуух



Британичууд Төвөдтэй зууралдаад байх боломж, сонирхол байсангүй. Тэр утгаар Төвөдийн орон зайг дайны дараахи Хятад, Энэтхэг хоёрын аль нэг нь эзэмших эрхтэй үлдсэн юм.

Томруулдаг шилээр Төвөдийг харвал

нутаг, хяр бэлийг стратегийн ач холбогдолтой тооцож ирсэн нь дэлхийн цээж рүү хүрэх гарах бүх гарц, зам харгүй уулзаж солбилцдогт оршино.

Аугаа их торгоны зам чухам үүгээр дамжин хоёр их тивийг, дөрвөн их иргэншлийг бие биетэй нь мэдүүлжээ. Товчхондоо дэлхийн түүхийн бичлэг ихэнхдээ энд төвлөрдөг буюу хөнддөг, ийм л их замын уулзвар байж ирсэн Төвөдийн тухай өгүүлж байна. Төв Азийн талын нүүдэлчид болох монголчууд, Хималайн хойд энгэрийн төвөдүүд, зүүн өмнөд хяраар аж төрөх бутанчууд, сиккимчүүд, Хималайн баруун хойд хөндий, Памиртай залгаа уулсад аж төрдөг ладакхчууд зэрэг өөр хоорондоо царай зүд, бие бялдар, аж төрлийн хувьд нэн ойролцоо, шарын шашин шүтдэг энэ таван үндэстэн хэзээ, хаана хамт байгаад хэдэн тийшээ тарж одсонг судалбал нэн сонирхолтой судалгаа гарах байх.

Оросын нэрт эрдэмтэн А.Дугин “Основы геополитики” хэмээх номынхоо “The Fall of China” гэж англиар гарчигласан дэд бүлэгт нэгэн ноцтой, сонирхолтой, осолтой санаа дэвшүүлжээ. Тэрбээр Монгол-Төвөдийн Холбооны улс байгуулах төсөл дэвшүүлэх хэрэгтэй гээд, тэр холбоонд Монгол, Төвөдөөс гадна Буриад, Тува, Хакас болон Алтайн БНУ-ыг оруулах, шарын шашны уламжлал бүхий эдгээр улс Москвагийн хувьд Хятадын эсрэг геополитикийн стратегид нь чухал зэвсэг мөн хэмээжээ. Тэгснээ эдгээр нэр бүхий улсуудыг Оросын хувьд “сулхан жигүүр” гэж нэрлээд, Евразийн гүн рүү Хятадыг нэвтрүүлэхгүй байхын тулд дорно, өмнө зүгээс нь Япон, Энэтхэгтэй нэгдэн холбоотон болж аваад Хятадыг хумих хэрэгтэй гэжээ. Чингэхийн тулд түүх рүү ухралт хийж Манжуурыг Хятадаас салган, Төвөд, Шинжаан, Монгол, Манжуурыг оролцуулсан Оросын аюулгүй байдлын бүслүүр бий болгох хэрэгтэй гэж уриалан дууджээ. Ийнхүү хойд, баруун, өмнө, зүүн жигүүрээсээ шахагдсан Хятад нь геополитикийн алдагдлаа хаашаа тэлж нөхвөрлөх вэ.

Энд Зүүн өмнөд Ази гэсэн ганцхан гарц Дугин санал болгохдоо, Вьетнамыг үл оролцуулан, харин Филиппин, Индонез, Австралийг чиглүүлсэн хойноос урагшаа гэсэн тэнхлэг гаргаж ирсэн байх юм. “Москва-Токиогийн тэнхлэг” хэмээх дэд бүлэгтэй сайх зохиогч “Евразийн буддист анклав” гэсэн орон зай үүсгэж, түүндээ Монгол, Өвөр Монгол, Төвөд, Халимаг, Тува, Буриадыг оруулбал Орос-Японы хооронд бат бэх холбоос, завсрын жигүүр бий болно гэсэн санаа дэвшүүлжээ. Соёл, шашин, арьсны нийтлэгтэй үндэслэсэн “Пан-Азийн буддист эвсэл” нь

Алс Дорнодод геополитикийн бат бөх бүтэц бий болгох чухал зэвсэг гэж Дугин үзжээ.

Философич Дугиний бичсэнээ санаа аван Монголын геополитикийн өнгөрсөн ба одоог эргэцүүлэхүй, хоёр их гүрний дунд орших Монгол нь хоёр хөршийн геополитикийн хайчинд хэр зэрэг хайчлагдаж тайрагдахаас шалтгаалж ирсэн гашуун түүх яг үнэн гэмээр. Газар зүйн хувьд хэт алслагдмал, тэс өмнөө (яг одоо бол бүр илэрхий) хоёр үндэстэн-Монгол, Төвөд хоёрыг яагаад заавал нэг саванд хийж, нэг самбар дээр тавих гээд байна вэ, энэхүү нөхөр Дугин гуай?

Дундад Иргэн улсын Засгийн газрын бүтэцэд Монгол, Төвөдийн Хороо хэмээсэн яам байж ирсэн ба өнөө ч Тайваньд бий. Большевикууд Гадаад Монголд ардын хувьсгал хийх сценари боловсруулахдаа гол ивээгч далд эзээр нь Коминтернийн Монгол-Төвөдийн тасаг гэгчийг Эрхүү хотоос тодруулсан Зөвлөлт Оросын Японы хооронд жийргэвч халхавч бүсийн хэлбэрээр бий болгосон Алс Дорнодын БНУ-ын Засгийн гарынхаа бүтэцэд мөн Монгол-Төвөдийн комисс байгуулж ажиллуулсан нь логикийн хувьд Дугиний санал болгосонтой холбоотой, ерөөсөө Москвагаас улбаалсан их гүрний геополитик ч байсан мэт.

Иргэншил, соёлын хувьд Төвөдийг ангилж тодорхойлоход түвэгтэй

Эдүгээ БНХАУ-ын нэг мужийн статустай байгаа Төвөдийн өөртөө засах орон нь 1950-иад оноос өмнө бол Хятадын бусад мужууд (Хөхнуур, Ганьсу, Сычуань, Юньань) дахь төвөдүүдийн нутгийг оролцуулан хоёр оршин суух ахуй, биологийн нөхцөл ч байсангүй. Энэ нь далайн түвшнээс хэт өндөрт (2500-4000 метр) орших, хөрс нь чулуулаг, үржил шим муутай, тодорхой нэр төрлийн цөөхөн ургамал тариалах, сарлаг мэтийн нүүдлийн мал аж ахуй эрхлэхээс өөр амьжиргаа байгаагүйтэй нь холбоотой.

Иргэншил-соёлын хувьд Төвөдийг ангилж тодорхойлоход түвэгтэй. Иргэншсэн үндэстэн яг мөн үү, шарын шашныг

авахаасаа өмнө тэд хэн байв, иргэншил нь олон улсын ямар нийтлэгт багтдаг гэхчлэн. Эдүгээ шарын шашин шүтдэг гэдгээр нь томъёолж болох авч уг шашин угаасаа тэдний уугуул шашин байсангүй, Энэтхэгээс орж ирсэн. Бурхан Будда багш өөрөө төвөдүүдтэй угсаа гарлын хувьд ойр байсангүй. Тэрбээр Балбын Люмбинид төрж өсөөд Энэтхэгийн Буддагаад гэгээрсэн, цаг тооллын хувьд Төвөдийн түүхээс нэн эртний бие хүн болно. Иймд Төвөдийн иргэншлийг Энэтхэгийнхэд угаасаа оруулж тооцож байсангүй, нүүдлийн гэдэгт тооцож ирсэн нь үгүй, өөрсдөө “нүүдэлчид” гэдгээр ханддаггүй. Төвөдийн түүхээс үзвэл, тэд нүүдлийн мал аж ахуй, газар тариалан хослуулан эрхэлдэг гар урлал зарим талаар хөгжсөн, үйлдвэрлэх хүчний хөгжил гэвэл маш доогуур. Буддын гэсэн хүчтэй иргэншил өнөөдөр барууны загалмайтны, күнзийн, лалынхтай өрсөлдөх хэмжээнд байна уу, үгүй юу, энэ бол эс үлдэх, тэсч үлдэхийн ирмэг дээрх асуудал бас биш.

Төвөдийн газар орны байршил, залгаа нутгууд нь Хятадтай илүү ойр дот байх ёстой атал тиймгүй, харин урагшаа барууншаа Энэтхэг, Балбатай нягт харилцаатай явж ирсэн нь төвөдүүд зам харилцаагаа хааш нь чиглүүлж түлхүү хөгжүүлсэн, шашнаа хаанаас авч, ямар хэмжээнд хөгжүүлж чадсан зэргээс үүдэлтэй. Нөгөө талаас Энэтхэг Сиккимээр дамжин Төвөд хүрэх стратегийн ашигтай зурвастай байсны үр дүн байсан хэрэг. Эндээс Лхас, Жамц хот хүрэх давуу нөхцөл Энэтхэгт байсан бөгөөд энэ хоёр хотод Консулын газраа ажиллуулж байсан түүх ч бий. Тэгвэл Дундад Иргэн Улс (ДИУ)-д, мөн БНХАУ-д ийм давуу байдал хэзэндээ байсангүй. Тэгэхээр Төвөдийн геополитикийг англи-энэтхэгчүүд тодорхойлж иржээ гэсэн үг.

Хятад-Энэтхэгийн хилийн дайн хоёр удаа дэгдэхдээ стратегийн хамгийн чухал түшиц газруудыг хөндсөн. Умард Кашмирээр ихээхэн газраа Пакистанд алдаж, Өмнөд Азийг Хятадтай холбосон Каракорумын засмал зам тавигдсанаар Энэтхэг нь Төв Ази руу нэвтрэх стратегийн харилцаагаа алдсан хэмээн өөрсдөө өнөө ч хүртэл гоморхдог. Төвөдийг Хятад бүрмөсөн чөлөөлж авснаар Энэтхэг нь Азийн өмнөд өнцөгт хүчээр хашигджээ. БНЭУ-ын Дотоод хэргийн яаманд нь Энэтхэг-Төвөдийн хилийн цагдаагийн газар хэмээх томхон алба (Хилийн цэргээ хэлж байна) бий. “Төвөдийн” гэж нэрлэж ирсэн нь стратегийн ба геополитикийн түүхэн ач холбогдлыг нь илтгэх мэт.

Түүхээс үзвэл Бирмийг Өмнөд Азийн зүүн хэсэг, чухамдаа Зүүн хойд Энэтхэгт хүрэх зурвас гэж

Хятадад үзэж ирсэн. Өөрөөр хэлбэл, Энэтхэгийн далайд Хятад улс гарах гарц хоолой юм. Энэ бүс нутагт хамаарах Бангладешийг Хятадаас бүх талаар дэмжиж ирсэн нь Энэтхэгийг бүс нутагт нь шахаж байгаа хэлбэр, мөн тэр хавийн Энэтхэг мужуудад (монголжуу гаралтай долоон муж бий) салан тусгаарлах иргэний дайн 40-50 жил үргэлжилсэн нь хаа хаанаасаа стратегийн сонирхолтой улс гүрнүүдийн далд оролцоо байхны гэж судлаачид үздэг.

Харин Монгол, Төвөд хоёр орчин цагт түүхэн ямар учир холбогдолтой юм бэ гэдэгт түүхэн хариулт хайя.

1913-1951 он бол Төвөдийн Дефакто тусгаар тогтнолын сүүлийн жилүүд байв

Орчин үеийн Төвөдийн түүх товч бөгөөд тодорхой. 1912 онд Британийн цэргийн даралт шахалт, Далай ламын шаардлагаар Хятадын цэрэг, ноёд Лхасаас дүрвэн гарч, 1913 оны нэгдүгээр сард Далай лам Энэтхэгээс Лхастаа буцан ирж, тусгаар тогтнолоо зарлажээ. 1913-1951 он бол Төвөдийн де-факто тусгаар тогтнолын жилүүд байв. Гэхдээ ДИУ-тай илүү бус удаа яриа хэлэлцээ хийж, ээр зэвсэг хангинуулах дээрээ тулж, Британийн нөлөө оролцоо хөндлөнгөөс байсны ачаар тэд тэсч үлдэжээ. Манай Монголын хувь заяа мөн иймэрхүү, СССР-ийн бамбай жийргэвчийн хэлбэрээр оршоор Ялтын бага хуралтай залдсан ба тэр үед Москва биднийг хаяагүй, харин тусгаар оршиж байгааг нь ДИУ-аар зөвшөөрүүлэхийг зорьсон. Тэр нь ч үр дүнд хүрсэн.

Британичууд Төвөдтэй зууралдаад байх боломж, сонирхол байсангүй. Дайны дараа Өмнөд Азиас гарч явах нь тодорхой, тэгээд ч Энэтхэгийг давуулан Хималайн хойд цэжинд өөрийн анклав үлдээгээд нэмэргүй. Тэр утгаар Төвөдийн орон зайг дайны дараах Хятад, Энэтхэг хоёрын аль нэг нь эзэмших эрхтэй үлдсэн юм. ДИУ Японы чөлөөлөгчид цаг хожих үүднээс Неруг ятгаж дэмжлэгийг эс олон, Дели дэх БНХАУ-ын Элчин сайдын эсэргүүцлийг олонтаа сонсон суусаар ар талдаа ялагдаж дуусчээ. Гэхдээ л тусгаар тогтнолын мөрөөдөл нь тасарсангүй, Сиккимээр дамжуулан НҮБ-д гомдол мэдүүлж хөөцөлдсөөр 1950 оныг үджээ.

Дэлхий дээр хэзээ ч дэмжлэг эс хүлээн, дипломатын талаар бүрэн тусгаар тогтнолын тухай орон 1951 оны хавар төлөөлөгчдөө Бээжин рүү арга буюу илгээж, сарын дараа гэхэд “Төвөдийг тайван замаар чөлөөлөх арга хэмжээний тухай хэлэлцээрт” гарын үсэг зурснаар төвөдүүд БНХАУ-ын ард түмнүүдийн өнөр гэр бүлд орж ирсэн билээ.

Сангийн сайдаа гадаад орнуудаар аялуулж байв.

Төвөдийн сайд бүтэн жил хагас гадаадаар явахдаа Энэтхэг, Хятад, АНУ, Британиар орж, М.Ганди, Ж.Неру, Чан Кайши, К.Эттли, Жорж Маршалл нарт бараалхаж цуцалтгүй зүтгээд нэмэр олсонгүй. 1949 онд коммунистууд БНХАУ-ыг байгуулсны дараа хамгийн сүүлчийн оролдлогоо хийжээ. 1949 оны арваннэгдүгээр сарын 4-нд төвөдүүд тусгаар тогтнолоо зарлан, хүлээн зөвшөөрүүлэхээр төлөөлөгч илгээсэн боловч цаадуул нь хүлээн авахаас татгалзав. Энэ үед Төвөдийн геополитик дээр Хятад, Энэтхэг хоёр тоглож эхэлжээ. Англичуудаас 1914 онд тулгаж Гадаад Төвөд, ДИУ-ын хооронд байгуулсан Симлагийн хэлэлцээр гэгчийг Неру 1950 онд Төвөд санал болгож, дайтахаас зайлхийхийг тэдэнд ятгажээ. 1914 оны тэрхүү хэлэлцээрээр Гадаад Төвөд гэгчид өөртөө засах онцгой эрх олгожээ. Тэгвэл Гадаад Монголд Хиагтын гэрээгээр хойтон жил нь Москвагаас тийм онцгой эрх олгосон байдаг. Гэхдээ тэр үедээ арга барагдсан Гадаад Монгол, Гадаад Төвөд хоёр 1913 онд гэрээ байгуулан, бие биеэ хүлээн зөвшөөрсөн байдаг нь түүхэн, гэхдээ эмгэнэлтэй үзэгдэл байсан болов уу.

1950 оны эхээр Хятадын ардын чөлөөлөх арми (ХАЧА) Төвөдийг нэвтрэн орж байлдаанаа эхэлж Төвөдийн цэрэг бут цохигдов. Энэ үеэр Дели хотноо Төвөдийн төлөөлөгчид цаг хожих үүднээс Неруг ятгаж дэмжлэгийг эс олон, Дели дэх БНХАУ-ын Элчин сайдын эсэргүүцлийг олонтаа сонсон суусаар ар талдаа ялагдаж дуусчээ. Гэхдээ л тусгаар тогтнолын мөрөөдөл нь тасарсангүй, Сиккимээр дамжуулан НҮБ-д гомдол мэдүүлж хөөцөлдсөөр 1950 оныг үджээ. Дэлхий дээр хэзээ ч дэмжлэг эс хүлээн, дипломатын талаар бүрэн тусгаар тогтнолын тухай орон 1951 оны хавар төлөөлөгчдөө Бээжин рүү арга буюу илгээж, сарын дараа гэхэд “Төвөдийг тайван замаар чөлөөлөх арга хэмжээний тухай хэлэлцээрт” гарын үсэг зурснаар төвөдүүд БНХАУ-ын ард түмнүүдийн өнөр гэр бүлд орж ирсэн билээ.

Энэ сценарийг Гадаад Монголоор жишээлэн зохиомжлон аваад үзвэл, Хэрэв Ялтад Монголын асуудлыг хөндөөгүй бол, ДИУ-ыг их гүрнүүд ятгаж тулгаагүй бол, хэрэв Сталин Маогийн саналыг хүлээн авсан бол 1911 онд эхэлсэн тусгаар тогтнолын түүх 1950-иад оны эхээр тэгсгээд өндөрлөх байлаа. Делид Неруг ятгаж асан Төвөдийн сайд нар, Сайн ноён хан Намнансүрэн Санкт-Петербургд Николай хаантай уулзахаар зориод бүтээгүй, Сочид амарч асан цагаан хааны араас нэхэж очиж тусгаар тогтнолоо ятгаж байсантай адил зам туулсан мэт.

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ
СОНИН ХҮМ

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэм хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатарын ДОЛГИОН

Тэргүүн орлогч эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО
Утас: 99997481

Орлогч эрхлэгч
Лхагважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦИ
Улс төр, нийгмийн мэдээллийн алба
Эдитор Б.Даваатогтох
Утас: 99901637

Эдийн засаг, бизнес мэдээллийн алба
Эдитор Б.Баяртогтох
Утас: 99901532

Гадаад контент, соёл энтертайментын алба
Эдитор Г.Баярсайхан
Утас: 99903574

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Э.Энхбаатар
Утас: 99903578

ХАЯГ
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайваны өргөн чөлөө,
“Бло Скай таур” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар: 1024
Утас: 70103131,
Факс: 70106065

ЦАХИМ ХУВИЛБАР
ubinfo.mn
Дугаарын удирдагч
Л.Сугармаа

985 580004291128 00723

ЗГМ: Сэдэв

Очих газраа олно гэдэг “оньсого таах”-тай адил

Жуулчид бүү хэл нийслэл дотроо бид төөрч, будилж явна

дугаарыг ч гурван оронтой тоогоор өөрчилжээ. Мэдээж өмнөх хаягаа тодорхой мэдэхгүй байгаа иргэдийн хувьд тун хүндэн асуудал болно.

Одоогийн байдлаар хөдөө орон нутгийн хаягжуулалт мэдээллийн сангийн 60 орчим хувьтай, харин нийслэлийн хаягжуулалт удаашралтай байгаа аж. Уг төслийг захиалагч болон хэрэгжүүлэгч хоорондын зөрчил үүссэнээс гацаанд оржээ.

АНУ-Д ОЧСОН ХҮН ТӨӨРДӨГҮЙ

Дэлхийн хамгийн том эдийн засагтай АНУ-ын аль ч хотод очсон хүн төөрдөггүй. Учир нь, гудамж, талбайн нэршил болон хаягжилт зориулалтын стандарттай. Хэрэгжүүлэгч байгууллагууд нь ч байнгын харилцаа холбоотой ажиллаж, шинэчлэл хийдэг байна. Тухайн гудамжны замын урд талын байшингууд сондгой тоотой, харин замын ард талынх нь тэгш тоотой гэх мэт.

Мөн хотын хэсэг болгон тусдаа кодтой. Нэр давхардах тохиолдол гарах боловч кодоороо зохицуулалт хийжээ. Тиймээс шуудангийн үйлчилгээ, хувь хүн, албан байгууллага, орон сууц, байшингийн хаяг, болон хотын газрын зураг хоорондоо огт зөрдөггүй байна. Гэтэл гаднын жуулчид Улаанбаатарт газрын зураг худалдаж аваад аялалд гарахад нөгөө л хаягжилт хүндрэл



С.Батсайхан / ЗГМФ

“Амар-санаагийн гудамж”, “Залуучуудын өргөн чөлөө”, “Рашаантын 18”, “Арцат”, “Сөүлийн гудамж” гэсэн нийт 164 хаяг байдаг боловч яг энэ нэрээр яг асууж сураглавал мэдэх хүн бараг олохгүй.

үүсгэдэг байна. Хэдийгээр газрын зураг дээр англиар тайлбар бичсэн боловч бүх гудамж, талбайн нэрийг хүртэл англиар бичихдэг. Тэгсэн хэрнээ бодит байдал дээр криллээр бичсэн байдлыг твиттер хуудаснаа нэгэн жуулчин нийтэлж байсан.

● **Шинэ хаягжуулалтын систем нэвтрүүлж байгааг мэдэж байгаа хүн алга.**

● **Улаанбаатар хотын хаягжуулалт эмх замбараагүйгээс болж төрөл бүрийн үйлчилгээнд олон бэрхшээл тулгарч байна.**

● **Нийслэлийн гудамж, талбайн хаягжуулалтаас гадна зуслангийн хаягжуулалт орхигдсоор өдийг хүрчээ.**

Энэ мэтчилэн гаднын жуулчид төөрөх нь бүү хэл нийслэл дотроо бид өөрсдөө төөрч, будилж явна. Хотын төвд хаягжилт ийм байхад гэр хороолол ямар байх нь бүр ч ойлгомжтой. 2013 онд баталсан Монгол Улсын хаягжуулалтын тухай хууль болон НИТХ-ын 2006 оны 269 дүгээр тогтоолд гэр хорооллын гудамжийг нэршүүлэх талаар огтхон ч дурдаагүй байна. Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газрын Хот байгуулалтын мэдээллийн хэлтсийн дарга Д.Уранбайгаль “Улаанбаатар хотын гудамж, талбайн нэршлийг ямар ч хүн өгөх

боломжтой.

Гэхдээ яагаад энэ нэрийг өгөх болсон, ямар гавьяа байгуулсан, тус гудамжийг нэрлэсэнээр ямар бүтээн байгуулалт хийх зэрэг хэдхэн зүйлс шаардлагатай. Ингээд бүх баримт, материалаа бүрдүүлсний дараа НИТХ-аар хэлэлцүүлнэ. Хэрэв зөвшөөрөгдвөл НИТХ-аар баталж, уг нэршлийг олгодог. Ерөнхийдөө гудамж, талбайн нэршлийг НИТХ-аар шийдвэрлэдэг” гэсэн юм. Сүүлийн үеийн шинэ орон сууцнууд хаягжилттай байдаг болохоос биш хуучны орон сууц, барилга байшин, орц, айл өрхүүдийнх тун хэцүү.

Хүрэх газраа олоход хагас цаг зарцуулах нь энүүхэнд

Нэг үгээр хэлэхэд, очих газраа олно гэдэг “оньсого таах”-тай адил. Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн хаяг ойлгомжгүй, эсвэл хэт нүсэр, зарим нь харингүй жижигхэн. Мөн хятад, солонгос, англи гээд олон төрлийн хэлээр бичихдэг. Монгол хэл дээр бичсэн

зарим хаяг алдаатай байдаг нь нууц биш. Энэ мэт Улаанбаатар хотын хаягжуулалт эмх замбараагүйгээс төрөл бүрийн үйлчилгээнд олон бэрхшээл тулгарч байна.

Хэрвээ хашаа бүр тодорхой хаягтай, хаалга бүр дугаартай бол ийм хүндрэл гарахгүй. Түүнчлэн Улаанбаатар хотын зуслангийн хаягжилт он удаан жил орхигдсон хэвээр. Угтаа Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын хэрэгжүүлээд эхэлсэн ажил үр дүнгээ өгвөл гэрийн хаягаа бусдад зааж өгөхийн зэрэгцээ түргэн тусламж, хөдөлгөөнт эргүүл болон хүргэлтийн үйлчилгээг авахад нэлээд хялбар болно. [ЗГМ]

ЗГМ ИНФОГРАФИК

НИЙСЛЭЛИЙН ГУДАМЖ, ТАЛБАЙН ХАЯГЖУУЛАЛТ



Оюунлаг хүмүүн Монголын баялаг 2017-2018 он



ДОТООДЫН ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

“Оюу толгой” компанийн Дотоодын тэтгэлэгт хөтөлбөр нь Монголын их, дээд сургуульд уул уурхайн чиглэлээр амжилттай суралцаж байгаа оюутан сурагчдад санхүүгийн дэмжлэг үзүүлээд зогсохгүй тэдний сурч хөгжих боломжийг дэмжих зорилготой. 2010 оноос хойш 230 оюутанд уг тэтгэлгийг олгоод байна.

2017-2018 оны хичээлийн жилд **25** оюутанд тэтгэлэг олгоно

ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ШАЛГУУР:

- Монгол Улсын иргэн байх
- Дотоодын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн 2, 3, 4 дүгээр дамбааны өдрийн ангийн оюутан байх
- Сурлагын голч дүн 3.2 ба түүнээс дээш байх (4.0 хүртэлх томьёоллоор)
- Бусад тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаагүй байх.

Дараах мэргэжлээр сурдаг байх. Үүнд:

- Геологи (геологи, геофизик)
- Геотехникийн инженер
- Маркшейдер, геодези
- Уул уурхайн ашиглалтын технологи
- Уул уурхайн цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт
- Уул уурхайн машин тоног төхөөрөмжийн инженер
- Баяжуулалтын инженер (ашигт малтмалын баяжуулалт, химийн технологи, металлурги, процессын инженер)
- Цахилгааны инженер
- Механикийн инженер

ТЭТГЭЛЭГТ ДАРААХ ЗҮЙЛС БАГТАНА:

- Сургалтын төлбөр
- Сар бүрийн тэтгэмж
- Хөдөө орон нутгийн оюутнуудын дотуур байрны төлбөр
- “Оюу толгой” ХХК-ийн Залуусын хөгжлийн хөтөлбөрт хамрагдах боломж
- Тус компанид дадлага хийх боломж

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

- Сургуулийн тодорхойлолт
- Суралцсан хугацааны дүнгийн баталгаат хуулбар
- Суралцсан хугацаанд үзүүлсэн амжилт, шагнал урамшууллын хуулбар
- Иргэний үнэмлэхний хуулбар
- “Надад мөрөөдөл бий” сэдвээр эссэ бичих (500-600 үгэнд багтаан, Times New Roman 11 фондоор, мөр хоорондын зай 1.5-аар бичнэ)

ӨРГӨДӨЛ ХҮЛЭЭН АВАХ ЭЦСИЙН ХУГАЦАА: 2017 ОНЫ 9-Р САРЫН 22-НЫ 18:00 ЦАГ

СОНИРХСОН ОЮУТНУУД

<https://www.jotform.com/70220698077459> хаягаар орж, өргөдлийн материалаа цахим хэлбэрээр Монгол хэл дээр (кирилл үсгээр) бүрэн гүйцэд бөглөж, шаардлагатай материалыг хавсралтаар илгээн үү. Утас: 11-331880 (3666), (3652)

- » Анхан шатны шалгаруулалтад тэнцсэн оюутнуудыг ярилцлагад урина.
- » Хугацаанаас хоцорсон болон дутуу бүрдүүлсэн материалыг шалгаруулалтад оруулахгүй болохыг анхаарна уу.

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА

ОРЧУУЛАГЧ:

Эдийн засаг, уул уурхай, улс төрөөр дагнан мэдээ, мэдээлэл нийтлэн уншигчдад хүргэдэг ЗГМСонин ХМХ нь Орчуулагч таныг ажилд урьж байна.

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Эдийн засаг, уул уурхайн чиглэлээр өргөн мэдлэгтэй байх,
- Эдийн засаг, уул уурхайн чиглэлээрх мэдээ мэдээллийг төлөвлөсөн хугацаанд орчуулан нийтлүүлэх,
- Мэдээний эх сурвалжийн утгыг алдагдуулалгүй орчуулгыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэх,
- Англиас Монгол болон Монголоос Англи хэл рүү орчуулга хийж байсан туршлагатай байх,
- Монгол хэлний өндөр мэдлэгтэй байх.

АЖИЛ ГОРИЛОГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Цаг хугацааны хувьд давуу, ажлын ачаалал ихтэй орчинд дасан зохиож, ачаалал дааж ажиллах туршлагатай байх,
- Сэтгүүл зүйн салбарт ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно,
- Багийн гишүүн байж, бусадтай үр дүнтэй хамтран ажиллах чадвартай байх,
- Хурдан, алдаагүй бичиж шивдэг байх,
- Төлөвлөлт болон бэлтгэл ажлыг оновчтой хийдэг байх,
- Англи хэлнээс гадна өөр хэл эзэмшсэн бол давуу тал болно,
- Холбогдох чиглэлийн Бакалавр болон Магистрын зэрэг, эсвэл ажлын туршлагатай байх.
- Хэрвээ та өөрийгөө дээрх ажлын байранд нийцэх боловсон хүчин гэж үзэж байгаа бол Англи болон Монгол хэлээр бэлтгэсэн CV-гээ бидэн рүү доорх хаягаар ирүүлээрэй. Бид тантай холбогдож дараагийн алхмуудыг хэлэлцэх болно.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

Ажилд орохыг хүссэн өргөдөл, анкет, гурван үеийн намтар, ерөнхий боловсролын гэрчилгээ, их, дээд сургуулийн диплом болон мэргэжлийн, үнэмлэхийн хуулбарыг нотариатаар баталгаажуулсан байх, 2 хувь цээж зураг (сүүлийн 3 сарын дотор авахуулсан), оршин суугаа хаягийн тодорхойлолт, өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт.



Ажилд орохыг хүссэн анкетыг “Засгийн газрын мэдээ сонин” ХМХ-ийн байранд ирж бөгөөд ба Dulamkhorloo.b@zasag.co, Baasan.b@zasag.co и-мэйл хаягт илгээж болно. Бүрдүүлэх материалын мэдээллийг 70103131 утсаар лавлана уу.

Мөнгөний урсгал

Шуурга сөрсөн тэрбумтнууд



Samsung Electronics-ийн хувьцааны ханш жилийн хугацаанд 60 гаруй хувиар өссөн

Өнгөрсөн жил Өмнөд Солонгосын хувьд нэлээд бужигнаантай жил болж өнгөрсөн. Ерөнхийлөгч нь шоронд хоригдож, хамгийн том конгломератын дэд ерөнхийлөгч авлигын хэргээр шүүхэд дуудагдаж, тэрчлэн пуужингаас хамгаалах Хойд Солонгосын эсрэг систем нь Хятадын эгдүүцлийг хүргэв. Солонгосчууд өөр зураа chaebol хэмээн нэрийддэг бизнесийн хамгийн том конгломератуудын удирдлагууд нь ч гэсэн тус улсын экс Ерөнхийлөгчийн дуулиант хэрэгт холбогдож, Үндэсний Ассамблейд байцаалт өгсөн нь түүхэнд байгаагүй юм. Эдгээр эрхмийн тав нь энэ жилийн жагсаалтад бичигджээ.

Гэсэн ч дээрх үйл явдал зах зээлд төдийлэн нөлөөлсөнгүй. БНСУ-ын хөрөнгийн биржийн зах зээлийн нийт үнэлгээний 22 хувийг бүрдүүлдэг Samsung Electronics-ийн хувьцааны ханш нэг жилийн хугацаанд 60 гаруй хувиар өссөний үр дүнд тус улсын Kospi жишиг индекс зургаан

хувиар дээшилжээ. Энэ үйл явцын ачаар Өмнөд Солонгосын хамгийн чинээлэг эрхэм Ли Күн-Хи хамгийн их долларын ашиг олсон хүнээр тодорч, хоёрдугаар байранд орсон эрхэмээс даруй хоёр дахин их хэмжээний хөрөнгөтэй болов. Samsung компанийн ТУЗ-ийн дарга хийдэг түүний хөрөнгө 4.2 тэрбум ам.доллаараар өссөн юм. Харин түүний гэр бүлийн холдинг компани Samsung C&T-ийн ихэнх хувьцааг эзэмшдэг, өдгөө хоригдож буй түүний хүү Ли Жэй Ёны хөрөнгө 6.2 тэрбум ам.доллаараас (гуравдугаарт) өөрчлөгдсөнгүй. Ам.доллаараар илэрхийлэгдэх хөрөнгө нь огцом өссөн эрхэм бол онлайн тоглоомын магнат Квон Хьюк-Бин. Түүний нийт хөрөнгө 1.2 тэрбум ам.доллаараар дээшилж, 6.1 тэрбум ам.долларт хүрчээ.

Энэ жилийн жагсаалт дахь тэрбумтнуудын эгнээнд гурван хүн шинээр нэмэгдсэн байна. Тодруулбал, гар утасны тоглоомын бизнесээр хөрөнгөжсөн Бан Жүн-Хьюк 24 дүгээрт, бэлэн хоолны салбарт тэргүүлэгч Ottogi-ийн Хам Ён-Жүн 47 дугаарт, аж үйлдвэрийн салбарын конгломерат Hyosung-ийн Чо Хён-Сан 49 дүгээрт (түүний ах нь 46 дугаарт бичигдэж буй) тус тус эрэмбэлэгджээ.

Үнэт цаасны MBK Partners компанийн хамтран үүсгэн байгуулагч Майкл Кимийн амжилт дагуулсан дөрөв дэх хөрөнгө оруулалт 4.1

тэрбум ам.долларын ашиг авчирч, тэрбээр энэ жилийн тэрбумтнуудын жагсаалтын 38 дугаарт бичигдэх боллоо. Тэрбээр ING Insurance Korea компани өнгөрсөн тавдугаар сард хөрөнгийн биржид бүртгүүлж, 977 сая ам.долларын хөрөнгө босгосон юм. Ингэснээр энэхүү хэлцэл БНСУ-ын хөрөнгийн зах зээлд энэ онд хийсэн хоёр дахь том IPO-д тооцогдож байна. Тэрчлэн БНСУ-ын Хөрөнгийн биржид хувьцаагаа нээлттэй арилжиж буй анхны хувийн үнэт цаасны фирм юм.

Тэгвэл өнгөрсөн жилийн жагсаалтад бичигдсэн ихэнх эрхмийн хөрөнгийн хэмжээ энэ жил буурчээ. Хамгийн их алдагдалд орсон эрхэм бол эм хангамжийн магнат Лим Сүнг-Ки. Түүний хөрөнгө 56 хувиар буурсан нь эмнэлзүйн туршилт хойшлогдож, дотоодын гурван корпоративтай байгуулсан гэрээ нь цуцлагдаж, нэмэлт өөрчлөлт орсонтой холбоотой. Хорт хавдар, чихрийн шижингийн эсрэг эм үйлдвэрлэдэг түүний Nanmi Science компанийн хувьцааны ханш 54 хувиар буурч, зах зээлийн үнэлгээ нь 4.5 тэрбум ам.доллаараар доошилсон ч Лим Сүнг-Ки тэрбумтны байр сууриа хадгалж, энэ жилийн эрэмбийн 15 дугаарт бичигджээ.

Нийт тэрбумтнуудын хөрөнгийн хэмжээг дөрөвдүгээр сарын 14-ний өдрийн хувьцаа, валют арилжааны хаалтын ханшаар тооцов.

Өсөж буй од



Улс төрийн хамгийн чинээлэг эрхэм нэгэнтээ өөрийгөө Өмнөд Солонгосын Берни Сандерс хэмээн нэрийдэж байсан нь нэг л авчлагдахуй байх шиг. Улс төрийн ноён нуруутай хэмээн өөрийгөө сурталчилдаг Ан Чол Сү “Бүхнээс ашиг хүртэж байдаг өв залгамжлагчид бус өөрийн хүчээр амжилтад хүрсэн залуусаар шинэ ирээдүйг цогцлооно” гэсэн уриатайгаар БНСУ-ын Ерөнхийлөгчийн ээлжит бус сонгуульд нэр дэвшсэн.

Үүнийг шинэчлэлийн төлөөх популист уриа гэж бодож байвал андуурч байна. Учир нь Ан бизнесийн монополийг эсэргүүцэгч юм. Сөүлийн их сургуулийг анагаах ухааны чиглэлээр төгссөн тэрбээр 1995 онд Ahn-Lab компани үүсгэн байгуулж, компьютерийн вирусийн эсрэг програм хангамжийг амжилттай зохион бүтээснээр өөрийн хөрөнгөө босгосон нэгэн.

Аравад жилийн дараа тэрбээр АНУ-ын Уортоны их сургуульд бизнесийн удирдлагын магистрын зэрэг хамгаалахаар гүйцэтгэх захирлын суудлаа хүлээлгэн өгчээ. Улмаар тус сургуульд профессор, шинжлэх ухаан, технологийн тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байгаад

боловсролын салбараас гарч, улс төрд оржээ.

Түүний сонгуулийн кампанит ажил ид овозлож байх үед буюу гуравдугаар сард AhnLab-ын хувьцааны үнэ эрс өссөн байна. Үүний дараахан компанийн зүгээс 2016 оны цэвэр ашиг 26 хувиар өссөн тухай албан ёсоор зарласан юм.

Түүний эзэмшлийн 18.6 хувьд ногдож хувьцааны үнэлгээ хоёр дахин нэмэгдэж, 245 сая ам.долларт хүрчээ. Гэсэн ч энэ нь түүний нэрийг улсын хамгийн чинээлэг 50 хүний тоонд оруулахад хангалтгүй байгаа юм.

Ан сонгуульд нэр дэвшсэн нь Ерөнхийлөгч Пак Гын Хэг огцруулан, баривчилсан дуулианы эцсийн эргэлт байлаа. Ерөнхийлөгчөөс гадна Samsung-ийн өв залгамжлагч Ли Жэй Ён зэрэг 30 хүн авлигын хэргээр торны цаана суусан билээ. Харин тэд ногдсон ял шийтгэлийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа юм.

Аны Ард түмний нам гол өрсөлдөгч Minjoo буюу Ардчилсан намаас тусгаарлаж, нэг жилийн өмнө Үндэсний Ассамблейд 38 суудал авч байв. Арванхоёрдугаар сард түүний бүлгэм Ерөнхийлөгч Пакийг албан тушаалаас огцруулахыг дэмжсэн Үндэсний Ассамблейн 300 гишүүнтэй нэгдсэнээр Ан Чол-Сү Ардчилсан намаас нэр дэвшигч Мүн Жаэ-Иньтэй Хөх ордны төлөө өрсөлдсөн билээ.

Ерөнхийлөгчийн сонгуульд хоёр дахь удаагаа өрсөлдсөн 55 настай Ан санал асуулгын дүнгээр Ардчилсан намын нэр дэвшигч Мүний хойно хоцорсон ч, Консерватив намын нэр дэвшигчийн өмнө гишгэв. Өнгөрсөн дөрөвдүгээр сард болсон нэр дэвшигчийн хурал дээр тэрбээр “Энэ улс уламжлалт болон дэвшилтэт үзэлтнүүдийн бус, харин ард түмний мэдэлд байдаг. Би та бүхнээс тусламж гуйхгүй, харин та бүхэнд туслах болно” хэмээн мэдэгдэж байжээ. **Forbes**

ӨМНӨД СОЛОНГОСЫН ХАМГИЙН ЧИНЭЭЛЭГ 10 ЭРХЭМ (Тэрбум)

1 ЛИ КҮН-ХИ

\$16.8 ▲

Samsung. Hac: 75

2 СУ КЫОН-БАЭ

\$6.7 ▼

Amorepacific. Hac: 54

3 ЛИ ЖЭЙ ЁН

\$6.2

Samsung. Hac: 48

4 КВОН ХЬЮК-БИН

\$6.1 ▲

Smilegate. Hac: 43

5 ЧҮН МОН-КҮ

\$4.5

Hyundai motor. Hac: 79

6 ЧЕЙ ТАЭ-ВОН

\$3.6

SK group. Hac: 56

7 КИМ ЖҮН-ЖҮ

\$3 ▼

Nexon. Hac: 49

8 ПАК ХЁН-ЖҮ

\$2.7 ▲

Mirae asset. Hac: 58

9 ЧҮН ЭЙ-СҮН

\$2.4 ▼

Gloviss & Hyundai motor. Hac: 46

10 ЛИ ЖҮН-КЫОН

\$2.3

Booyoung. Hac: 76

▲ 10 хувиас илүү өссөн

▼ 10 хувиас илүү буурсан

НЭРИЙН ХУУДАС

Шинэ тэрбумтан цахиур хагалав



Өнгөрсөн жил 1.3 тэрбум ам.долларын орлоготой ажиллаж, дээд түвшнээ эвдсэн, БНСУ-ын гар утасны тоглоомын хамгийн том компани Netmarble өнгөрсөн тавдугаар сард IPO хийж, 2.3

тэрбум ам.доллар босгоод байна. Энэ нь БНСУ-ын хэмжээнд сүүлийн долоон жилийн хамгийн том IPO-д тооцогдож буй бөгөөд компанийн зах зээлийн нийт үнэлгээ 12 тэрбум ам.долларт хүрчээ.

Ингэснээр компанийн үүсгэн байгуулагч, өдгөө 24 хувийг нь эзэмшиж буй Бан Жүн-Хьюкийн хөрөнгө хоёр дахин өсөөд байна. БНСУ-ын тэрбумтнуудын жагсаалтад энэ жил анх бичигдэж

буй Бан 1.43 тэрбум ам.долларын хөрөнгөтэйгөөр 24 дүгээрт эрэмбэлэгдлээ. Ядуу зүүдү өсөж, ахлах сургуулиа орхисон тэрбээр энэ түвшинд хүрэхийн тулд их хүнд замыг туулсан аж. Netmarble-ийн тоглоомын борлуулалтын 51 хувь нь гадаадаас хийгддэг бөгөөд Бан өдгөө бизнесээ хилийн чанадад тэлэхээр эхэлжээ. IPO хийж, босгосон хөрөнгөөрөө томоохон худалдан авалт хийхээр төлөвлөсөн байна.

Гоймонгийн вант улс



Хүнсний салбарт үйл ажиллагаа эрхэлдэг Хам Ён-Жүн Forbes-ийн жагсаалтад анх удаа орж, 725 сая ам.долларын хөрөнгөтэйгөөр 47 дугаарт бичигджээ. Өмнөд Солонгосын бэлэн гоймонгийн салбарыг эзэгнэгч Ottogi компанийг үүсгэн байгуулсан түүний эцэг Хам Таэ-Хо-г өнгөрсөн есдүгээр сард 86 насандаа өөд болоход өвлөн авсан хувь эзэмшлээс түүний хөрөнгө

бүрддэг. Өдгөө тэрбээр компанийн 29 хувийг эзэмшиж буй. Уг гэр бүлийн удам залгах цорын ганц хүү Хам 2010 оноос хойш компаниа удирдаж, бэлэн гоймонгийн зах зээлд эзлэх хувь хэмжээгээ тэлсээр байгаа юм. Тэрбээр хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийнхаа ТУЗ-ийн даргын алба хашдаг бөгөөд өнгөрсөн жил 1.7 тэрбум ам.долларын борлуулалттай ажилласан Ottogi компанийн нийт ашиг 114 сая ам.долларт хүрчээ. Таэ-Хо 1969 онд Ottogi компанийг байгуулж, кетчуп, майонезийг эх орондоо анх удаа үйлдвэрлэж байжээ. Улмаар хүрээгээ тэлж, гурван минутын

дотор бэлэн болдог хоол хүнс, хагас боловсруулсан, хөлдөөсөн хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж эхэлсэн байна. Өдгөө Ottogi-ийн бүтээгдэхүүн Өмнөд Солонгост салбартаа хамгийн шилдэгт тооцогддог бөгөөд тус улсад үйл ажиллагаа явуулдаг McDonald's түргэн хоолны сүлжээ компанийн цорын ганц бэлтгэн нийлүүлэгч юм. Таэ-Хо-гийн 1996 онд үүсгэн байгуулсан Ottogi Foundation-ийг гэр бүл нь авч явдаг бөгөөд коллежийн оюутнуудад санхүүгийн тэтгэлэг олгодог. Тэрчлэн үүсгэн байгуулагч нь хүүхдийн эрүүл мэндийн хөтөлбөрт харамгүй мөнгө хандивладаг байжээ.

Тоглоом дуусах болоогүй



БНСУ-ын онлайн тоглоомын хамгийн том компани Nexon-ийн үүсгэн байгуулагч Ким Жүн-Жү авлигын хэргээр өнгөрсөн долдугаар сард шүүхийн хаалга татсан

ч арванхоёрдугаар сард Сөүл хотын шүүхээс гэм буруугүйг нь нотолж, цагаатгажээ. Түүнийг Сөүлийн Үндэсний Их Сургуульд хамт сурч байсан прокурор Жин Кыон-Жүнд мөнгө өгсөн хэмээн сэжигэсэн юм. Ким түүнд тодорхой хэмжээний мөнгө өгснөө хүлээн зөвшөөрсөн ч нотлох баримт хангалтгүйн улмаас аль аль нь цагаатгагджээ. Харин прокурорын газраас дахин зарга үүсгэхээр эхэлж буй. Уг хэргийн

дараа тэрбээр олон нийтээс албан ёсоор уучлал гуйж, Nexon-ийн удирдах зөвлөлөөс нэрээ татжээ. Энэ жилийн тэрбумтнуудын жагсаалтын долдугаарт бичигдэж буй Ким Жүн-Жү өдгөө Nexon-ийн холдинг компани болох, Токиогийн Хөрөнгийн биржид хувьцаагаа арилждаг NXC-ийн ТУЗ-ийн дарга хэвээр байгаа юм. Түүний нийт хөрөнгийн хэмжээ өнгөрсөн жил 27 хувиар буурчээ.

ТҮРЭЭСЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР

ДЦС-4 ТӨХК-н түрээслэх талбайн танилцуулга:

1. Үйлчилгээний зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Ахуйн байр 2-т байрлах 421.2м.кв талбай бүхий өрөө
2. Үйлчилгээний зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Ахуйн байр 2-т байрлах 182м.кв талбай бүхий өрөө
3. Үйлчилгээний зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Ахуйн байр 2-т байрлах 51.8м.кв талбай бүхий өрөө
4. Үйлчилгээний зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Ахуйн байр 2-т байрлах 150м.кв талбай бүхий өрөө
5. Үйлчилгээний зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Ахуйн байр 2-т байрлах 245.5м.кв талбай бүхий өрөө
6. Үйлчилгээний зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н зүүн талд байрлах засварын барилга 156.3м.кв талбай бүхий өрөө
7. Үйлчилгээний зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Ахуйн байр 2-т байрлах 105м.кв талбай бүхий өрөө
8. Үйлчилгээний зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Ахуйн байр 1-н 3а-д байрлах 60м.кв талбай бүхий өрөө
9. Үйлчилгээний зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Эрчим-1 зааланд зоорин давхарт байрлах 223.84м.кв талбай бүхий өрөө
10. Үйлчилгээний зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Ахуйн байр 2а 1 тоот 35м.кв талбай бүхий өрөө
11. Үйлчилгээний зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Ахуйн байр 2а 3 тоот 82м.кв талбай бүхий өрөө
12. Үйлчилгээний зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Ахуйн байр 2а 4 тоот 37м.кв талбай бүхий өрөө
13. Үйлчилгээний зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Ахуйн байр 2а 5 тоот 45м.кв талбай бүхий өрөө
14. Үйлчилгээний зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Ахуйн байр 2а 6 тоот 8,7м.кв талбай бүхий өрөө
15. Үйлчилгээний зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Ахуйн байр 2б 1 тоот 23м.кв талбай бүхий өрөө
16. Үйлчилгээний зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Ахуйн байр 2б 2 тоот 26м.кв талбай бүхий өрөө
17. Албан тасалгааны зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Захиргааны 2-р байранд 12м.кв талбай бүхий өрөө
18. Албан тасалгааны зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Захиргааны 2-р байранд 36м.кв талбай бүхий өрөө
19. Албан тасалгааны зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Захиргааны 2-р байранд байрлах 103 тоот 18м.кв талбай бүхий өрөө
20. Албан тасалгааны зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Захиргааны 2-р байранд байрлах 106 тоот 24м.кв талбай бүхий өрөө
21. Албан тасалгааны зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Захиргааны 2-р байранд байрлах 107 тоот 24м.кв талбай бүхий өрөө
22. Албан тасалгааны зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Ахуйн байр 3а-д байрлах 145м.кв талбай бүхий өрөө
23. Албан тасалгааны зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Захиргааны 2-р байранд байрлах 113 тоот 51м.кв талбай бүхий өрөө
24. Албан тасалгааны зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Захиргааны 2-р байранд байрлах 114 тоот 24м.кв талбай бүхий өрөө
25. Үйлчилгээний зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Захиргааны төв байрны барилгын Дөл танхимд байрлах 7,22м. кв талбай бүхий өрөө
26. Үйлчилгээний зориулалтаар: ДЦС-4 ТӨХК-н Захиргааны төв байрны барилгын Дөл танхимд байрлах 11,9м. кв талбай бүхий өрөө

ДЦС-4 ТӨХК-н эд хөрөнгийг түрээслэх сонирхолтой хуулийн этгээд, аж ахуйн нэгж, иргэдээс төрийн өмчийн эд хөрөнгө түрээслэх сонгон шалгаруулалтад оролцох битүүмжилсэн материал ирүүлэхийг урьж байна.

Сонгон шалгаруулалтад бүрдүүдэх материал. Үүнд:

- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ /иргэний хувьд цахим үнэмлэх/, эрх бүхий байгууллагаас олгосон үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн нотариатаар баталгаажуулсан хуулбар
- Үйл ажиллагааны танилцуулга, ажлын туршлагын талаархи мэдээлэл /өмнө нь хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлыг бичиг/
- Санхүүгийн чадварыг нотлох баримт /иргэн, хуулийн этгээдийн харилцагч банкны баталгаажуулсан дансны тодорхойлолт/
- Ажиллах хүчний мэдээлэл, мэргэжлийн диплом, үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбар
- Талбай болон эд хөрөнгө түрээслэх үнийн санал
- Талбай болон эд хөрөнгө түрээслэх үнийн саналын дагуу 3 сарын түрээсийн төлбөртэй дүйцэхүйц барьцаа байршуулах боломжтойг нотолсон баримт бичиг /дансны хуулга/

Материалыг доорхи хаягаар ирүүлнэ. Улаанбаатар хот. Баянгол дүүрэг. 20-р хороо Эрчим хүчний гудамж. ДЦС-4 ТӨХК-ний 2-р байр. 3 давхар 323 тоот өрөө. Утас: 70001184, 99191608, 95095904

Материалыг 2017 оны 09 дүгээр сарын 21-ны өдрийн 10 цаг 30 минутаас өмнө дээрхи хаягаар ирүүлэх ба /хугацаа хоцорсон материал хүлээн авахгүй/ нээлтэд оролцох хүсэлтэй оролцогчдыг байлцуулан материалыг 2017 оны 09-р сарын 21-ны 11 цаг 00 минутад нээнэ.

Сонголт

Тансаг зэрэглэлийн даалин 1-15 сая төгрөгийн үнэтэй

Б.Баярмаа
@bayarmaaZGM

Даалин бол монголчуудын олон зуун жил хэрэглэж ирсэн наанаа чамин хээтэй, цаанаа нандин бэлгэдэлтэй эд. Даалинг анх хэддүгээр зууны үед, хэн зохиосон нь бүрхэг. Гэвч энэ эдлэл монголчуудын өв соёл, уламжлал, түүхийг тээсээр өнөөдөртэй золгожээ.

Өдгөө зөвхөн уламжлалт баяраар бус, өдөр тутамдаа хөөрөг, даалин хэрэглэдэг хүн цөөнгүй харагддаг болсон. “Нарантуул”, “Хар хорин” зэрэг худалдааны төвүүдэд даалингийн үнэ 5000 төгрөгөөс эхэлж байна. Гэвч нийтийн хэрэглээнд зориулсан хямд үнэтэй, олноор нь үйлдвэрлэсэн ийм даалингаас уг эдийн үнэ цэнэ “үнэртдэггүй”. Тиймд монгол ардын ур ухаан, уламжлал, бэлгэдэл шингэсэн тансаг даалингийн зах зээл рүү онгийлөө.

Социалист нийгмийн үед айлын авдарт хав дараастай байсан энэ эд өдгөө жижиг ч гэсэн тансаг хэрэглээний зах зээл бий болгожээ. Ашигласан торго, угаснаас эхлээд ямар ур хийц орсноосоо шалтгаалан янз бүрийн үнэтэй. “Даалингийн үнэ цэнэ нь ур хийц, давтагдашгүй чанартаа байдаг. Тухайн хүний үзэл бодол, сонирхол, нийгмийн байр суурийг тодорхойлдог эд” гэж Уран хатгамлын улсын хоёрдугаар уралдааны аварга, уран хатгамалч С.Нарандэлгэр өгүүлэв. Тэрбээр 10 гаруй жил даалин урлаж буй бөгөөд урласан даалин нь хэзээ ч давтагддаггүй. Бүтээл нь хамгийн багадаа нэг сая төгрөгийн үнэтэй. Харин



Даалингийн үнэ цэнэ нь ур хийц, давтагдашгүй чанартаа байдаг. Тухайн хүний үзэл бодол, сонирхол, нийгмийн байр суурийг тодорхойлдог эд.

С.Батсайхан / ЗГМ©

Өв тээсэн “нэрийн хуудас”

Өдөрт найман цаг зарцуулбал 1-2 сарын дотор нэг даалин оёдог

лагаа орсон даалингийн үнэ нэг сая төгрөгөөс эхэлдэг. Тухайлбал, хатгамалч Ц.Энхжаргалын урласан 43x19 хэмжээтэй, хаан бугуйвч, хатан сүйх бүхий дунд гарын даалин нэг сая төгрөгийн үнэтэй. Харин дөрвөн хүчтэнийг

аавдаа өгөх нь үнэтэй бэлэгт тооцогддог тул бэлдэж авч, өөрсдөө урлах нь түгээмэл болжээ.

Харин бүсгүйчүүдийн хөөрөгөө хийдэг уутыг хавтаг гэдэг. Хөөрөгөөс гадна үнэртэн, гоёл чимэглэлээ хийж болно. Өдгөө бүсгүйчүүд хавтаг хэрэглэх нь өдрийн од шиг болсон. Энгийн хийцтэй хавтагийг 100-200 мянган төгрөгөөр борлуулж байна.

Даалин үеэс үед, өвөг дээдсээс хойч үед өвлөгдөгдөөрөө онцгой. Тиймд түүнийг эдлэгээ дах чадвар чухал. Манайд хятад, индонез, тайланд гээд төрөл бүрийн торго борлуулдаг. Эдгээрээс эдлэгээ даах чанараараа япон торго илүү үнэлгээ авдаг байна. Мөн хатгамалчид япон утас, зүү түлхүү хэрэглэдэг. Уран хатгамалч С.Нарандэлгэр “Японоос хүр хорхойн торго болон бусад материалаа авдаг. Япон торго нь оёдол сайн даадаг, оёдлоо ханзалсан ч цаана нь зүүний ором гардаггүй, урагдаж сэмэрдэггүй. Ийм материалтай даалин 3-4 үеийнхний эдлэгээ даана. Нэг даалин хийхэд их бие, эмжээр, дотор гээд 450-550 мянган төгрөгийн материал ордог юм” гэв. Хэрэв чанар муутай торгоор уралбал нугалаасаараа амархан сэмэрч, урагддаг юм байна.

Даалингийн эдлэгээ, чанарт дотор торго нь мөн чухал. Хүр хорхойн шүлсээр хийсэн сайн торго ашиглавал хөөргийг будаг болгохгүй, барихад хөөрөг нь гулдагдгүй давуу талтай.

Нэг даалин оёход өдөрт найман цаг зарцуулбал 1-2 сарын дотор дуусгадаг. Харин хатгамал, нарийн чимхлүүр ажиллагаа их бол жил дамнах нь ч бий. Монголчуудын гар урлалын арвин санд

оёдол, хатгамлын 100 гаруй төрөл байдаг. Үүнээс даалинд зүү ороох, задгай хатгах, зээг дарах зэрэг 20 орчмыг нь ашигладаг юм байна.

Өмнө нь даалинг настайчууд ихэвчлэн хэрэглэдэг байсан бол сүүлийн жилүүдэд худалдан авагчид дунд залуус давамгайлах болсон байна. Мөн 3D буюу гэрэл, сүүдэртэй хатгамал моодонд оржээ. Гэхдээ 3D хатгамал бол шинэ зүйл биш. Учир нь хэзэ угалзыг гэрэл, сүүдэрэр давхарлаж зурсан эд монгол ахуйд эртнээс хэрэглэдэг байсан. Ту-

хайлбал, монгол авдрыг чимдэг давхар хээ, угалзаас үүнийг харж болно. Харин 3D хэмээн нэрлэж, зохиомжийг нь орчин үеэтэй холбооноор залуус сонирхох болсон.

Даалинг хатгамал, хээ угалзаас гадна калиграфар чимж болно. Тухайн хүний нэрээс эхлээд хүссэнээ хатгаж болно. Харин сүүлийн үед ардаа дугуй хээтэй даалин оёх болсон нь монгол уламжлалтай нийцэхгүй гэдгийг хатгамалчид хэлж байлаа. Учир нь даалин бол дээшээ харсан амсартай, эд баялаг, буян арвижихыг бэлгэддэг уут, сав.

Гэтэл арын хэсгийнхээ голд буй хээг харуулахын тулд даалингийн амсраа доош харуулж барих нь ёсонд нийцдэггүй. 1980-аад оноос хойш л даалингийн ард ийм хээ оёж, чамирхдаг болсон аж.

Даалин хэрэглэхдээ гуравны нэгийг нь нугалж өвөр дээрээ тавьдаг, бүсэндээ хавчуулдаг. Ингэж нугалахад үлдсэн хэсэгт нь хээ, зохиомж нь бүрэн харагдаж байхаар зохиомжлох хэрэгтэй. Хэрэв хээ нь буруу нугалагдсан, дарагдсан бол буруу гэж үздэг байна. [ЗГМ]



сор болсон бүтээлүүд нь 15 сая төгрөгт хүрдэг байна. Тэрбээр “Чингисийн эр хоёр загалын тууж”-аас сэдэвлэсэн даалин урлажээ. Харин өдгөө Б.Шаравын “Монголын нэг өдөр” зургаас сэдэвлэсэн бүтээл урлаж буй. Эр нь торго сайтай, гар ажил-

буландаа “залж”, голд нь очир хатгасныг 3.5 сая төгрөгөөр үнэлжээ. Мөн торгон дээр хээ, зургийн зурсан бэлдэцийг худалдан авч болно. Мөн л хээ, хатгамал, материалаасаа шалтгаалан 25-60 мянган төгрөгийн үнэтэй. Бүсгүйчүүд нөхөртөө,

УРИАЛГА



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА М.ЭНХБОЛД, УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДЭД

Монгол Улсад нүүрлээд байгаа улс төрийн намуудын дотоод зөрчил нь монгол төрийн тогтвортой байдлыг алдагдуулахад хүрч, улмаар гадаадын шууд хөрөнгө оруулалт буурах, валютын ханш болон гадаад худалдааны алдагдал өсөх ноцтой үр дагаварт хүргэхээр байна. Сүүлийн жилүүдэд Засгийн газрын өрийн хэмжээ өсөж, улсын төсвийн алдагдал нэмэгдсэн нь эдийн засагт ихээхэн дарамт болж эдийн засаг саарахад хүргэлээ. Эдийн засгийн хямралтай байгаа ийм үед энэ оны эхний хагас жилийн байдлаар эдийн засгийн зарим үзүүлэлтүүд эерэг дүр зурагтай гарсан нь бизнес эрхлэгчдийн хувьд бага ч атугай найдвар төрүүлсэн юм.

Хямралтай эдийн засгийг зөв хөгжлийн бодлогоор удирдан залж, бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчдын дэмжлэгтэйгээр тогтвортой өсгөх үүрэгтэй төр, засаг өнгөрсөн 25 жилд дунджаар 1.7 жилийн хугацаатай 14 гүйцэтгэх засаглалтай байж, төрийн залгамж халаа алдагдаж, бодлогын хувьд харилцан уялдаагүй ажиллаа. Өнөөгийн улс төрчдийн хариуцлагагүй үйлдлээс болж бизнес эрхлэгч, хөрөнгө оруулагчид өөрсдийн үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх, ажлын байрыг хадгалах, нэмэгдүүлэх улмаар татвар, шимтгэл төлөхөд ихээхэн хүндрэлтэй болж байна.

Бизнес эрхлэгчид өнөөдрийг хүртэл Засгийн газрын боловсруулсан “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр” болон эдийн засгийн тэргүүлэх салбарыг хөгжүүлэхээр авч хэрэгжүүлсэн бодлого, шийдвэрээс тодорхой, эерэг үр дүнг хүлээсээр байлаа.

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим нь бизнес эрхлэгчдийн дуу хоолойг илэрхийлэгчийн хувьд төрийн эрх баригчдаас өөрсдийн үүрэг, хариуцлагыг ухамсарлан, улс орны хөгжлийг нэн тэргүүнд тавьж, **ТОГТВОРТОЙ, ЧАДВАРЛАГ ГҮЙЦЭТГЭХ ЗАСАГЛАЛТАЙГААР ХӨГЖЛИЙН УРТ ХУГАЦААНЫ ОНОВЧТОЙ БОДЛОГЫГ ТОДОРХОЙЛОН, БИЗНЕС ЭРХЛЭГЧИДТЭЙ ХАМТРАН ТУУШТАЙ ХЭРЭГЖҮҮЛЭХИЙГ** уриалж байна.

МУХАУТ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ТЭРГҮҮЛЭГЧИД

2017.09.15

НЭЭЛТТЭЙ АЖЛЫН БАЙРАНД УРЬЖ БАЙНА

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

Эдийн засаг, уул уурхай, улс төрөөр дагнан мэдээ, мэдээлэл нийтлэн уншигчдад хүргэдэг ЗГМ Сонин ХМХ нь Борлуулалтын менежер таныг ажилд урьж байна.

АЖЛЫН БАЙРАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Сурталчилгаа, борлуулалтыг нэмэгдүүлэх чиглэлээр байнгын харилцагчдын хүрээллийг тогтмол гэлэх санаачилга гаргах,
- Гэрээ хэлэлцээр хийх, албан бичиг боловсруулах, танилцуулах чадвартай байх,
- Борлуулалтын хэлцэл хийх уулзалт зохион байгуулж, танилцуулга бэлтгэх, танилцуулах,
- Байгууллагаас захиалсан сурталчилгааг хүлээн авах, хянаж, эцсийн байдлаар хүлээлгэн өгөх,
- Байгууллагын бусад ажилтнуудтай хамтран ажиллах.

АЖИЛ ГОРИЛОГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- Цаг үеийн өөрчлөлтийг мэдэрч, шинэ санаачилга гарган, үүнийг хэрэгжүүлэх, хянах, тайлагнах чадвар маш чухал,
- Удирдагч, манлайлагч, шинийг санаачлагч байхаас гадна багаар ажиллах чадвартай байх,
- Бизнесийн салбарт хүрээлэлтэй бол давуу тал болно,
- Төлөвлөлт болон бэлтгэл ажлыг оновчтой хийдэг байх,
- Англи болон Орос хэлийг төгс эзэмшсэн бол давуу тал болно
- Холбогдох чиглэлийн Бакалавр болон Магистрын зэрэг, эсвэл ажлын туршлагатай байх.

Хэрвээ та өөрийгөө дээрх ажлын байранд нийцэх боловсон хүчин гэж үзэж байгаа бол Англи эсвэл Монгол хэлээр бэлтгэсэн CV-ээ биднэ рүү доорх хаягаар ирүүлээрэй. Бид тантай холбогдож дараагийн алхмуудыг хэлэлцэх болно.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛУУД:

Ажилд орохыг хүссэн өргөдөл, анкет, гурван үеийн намтар, ерөнхий боловсролын гэрчилгээ, их, дээд сургуулийн диплом болон мэргэжлийн, үнэмлэхүйн хуулбарыг нотариатаар баталгаажуулсан байх, 2 хувь цээж зураг (сүүлийн 3 сарын дотор авахуулсан), оршин суугаа хаягийн тодорхойлолт, өмнө нь ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт.



“Засгийн газрын мэдээ сонин” ХМХ-ийн байранд ирж бөгөөх ба Dulamkhorloo.b@zasag.co, Baasan.b@zasag.co и-мэйл хаягт илгээж болно.

Утас: 7010-3131

Анкетыг “Засгийн газрын мэдээ сонин” ХМХ-ийн байранд ирж бөгөөх ба Dulamkhorloo.b@zasag.co, Baasan.b@zasag.co и-мэйл хаягт илгээж болно.

Утас: 7010-3131

Лавлах

ҮЗЭСГЭЛЭН

“Намрын ногоон өдрүүд” эхэллээ

М.Мөнхзул
ЗГМ

Шинэ ургацын жимс, хүнсний ногоо худалдаалах “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдаа энэ сарын 19-25-нд “Мишээл экспо” төвд зохион байгуулагдаж байна. Үзэсгэлэнгийн үеэр нийт 430 цэгт жимс, хүнсний ногоо борлуулах юм. Тус арга хэмжээ нь хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, үндэсний үйлдвэрлэгч, тариаланчдын шилдэг бараа бүтээгдэхүүн, шинэ ургацын дээжийг хэрэглэгчдийн гарт шууд хүргэх зорилготой. Арга хэмжээний үеэр “Органик хөдөө аж ахуйг дэмжье”, “Амтат балны ашиг тус”, “Эх орны сүү-Эрүүл хүнс”, “Ногоон хүнс-эрүүл амьдрал” өдөрлөгүүдийг тус тус зохион байгуулна. [ЗГМ]

БҮРТГЭЛ

Шүүгчийн сонгон шалгаруулалтад бүртгэнэ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2017 оны 85, 86 дугаар тушаалаар зарласан анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн суурь шалгалт, давж заалдах шатны шүүхийн шүүгч, хяналтын шатны шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн сонгон шалгаруулалтад оролцох нэр дэвшигчдийг бүртгэж байна. Нэр дэвшигчдийн материалыг есдүгээр сарын 19-ний өдрийн 09.00 цагаас 22-ны өдрийн 17.00 цаг хүртэл авах юм. Бүртгэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн 70008022 утсаар лавлах боломжтой. [ЗГМ]

БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

Цэцэрлэгтэй боллоо

Засгийн газраас гаргасан “Хүүхэд бүр цэцэрлэгт” хөтөлбөрийн хүрээнд өнгөрсөн жилээс эхлэн зарим яам өөрийн байрандаа ажилчдынхаа хүүхдүүдэд зориулсан тохилог цэцэрлэг байгуулж эхэлсэн. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам уг ажлыг үргэлжлүүлэн 80 хүүхэд хүлээн авах чадалтай цэцэрлэг байгуулж, бүрэн ашиглалтад орууллаа. Тус цэцэрлэг нь 37 дугаар цэцэрлэгийн харьяа бөгөөд бага, дунд гэсэн хоёр бүлэгт багачуудыг хүлээн авах юм байна. [ЗГМ]

СОНИУЧХАН

Нойргүйдлээс аврах шидэт бүтээлэг

Нойргүйдэл эсвэл тайван бус нойр зарим хүнийг зовоодог. Бага дээр нь шалтгааныг олж эмчлэхгүй бол бие махбодь төдийгүй сэтгэл зүйд муугаар нөлөөлдөг. Тэгвэл пластик гранул, шош, вандуй, будаа, буудайг тусгай уутнуудад хийж бэлтгэсэн бүтээлэг нойргүйдэлтэй тэмцэх шилдэг “зэвсэг” болоод байна. Уг бүтээлэг нь аз жаргалын гормон болох серотонин, нойрны гормон болох мелатонин ялгаруулдаг аж. Хүүхдийн эмнэлэг энэ аргыг олон жилийн хугацаанд ашиглаж байгаа бөгөөд өвчтөндүүдээ бүтэн нойртой хонуулах шилдэг арга гэж үздэг. Аутизмаар шаналж буй олон хүүхдийн эцэг эх энэ бүтээлгийн ид шидийг мэдэрсээ. Энэ бүтээлгийг ашиглахад насны хязгаар үгүй. Бүтээлгийн жин нөмрөх хүний биеийн жингийн 10 хувьтай тэнцэнэ гэж үздэг. Хэрвээ та 70 кг жинтэй бол бүтээлгийг долоон кг будаа, буудай зэргээр жигд дүүргэнэ гэсэн үг. Гэхдээ цусан хангамж болон амьсгалын бэрхшээлтэй хүмүүст тохиромжгүйг мэргэжлийн хүмүүс анхааруулж байна. [ЗГМ]

ТВ ХӨТӨЛБӨР

	MNB	Bloomberg	Боловсрол	Монгол ТВ
08.00	09.00 “Далд ертөнц” УСК 1, 2 дугаар анги	08.00 “Bloomberg Daybreak Asia”	08.05 “Монголчууд XX-р зууны эхэнд” нэвтрүүлэг	06.30 Өнөө өглөө
12.00	11.00 “Монголын мэдээ” мэдээллийн хөтөлбөр	11.35 “Байршил” нэвтрүүлэг	14.10 “Хүрээлэн” амьд ертөнц нэвтрүүлэг /82-83-р цуврал/	12.30 Тэр хөрөг нэвтрүүлэг
14.00	14.00 “Цэлмэг” өдрийн хөтөлбөр / шууд/	14.00 “Чарли Роузын ярилцлага” нэвтрүүлэг	14.10 “Үүнийг хэрхэн хийдэг вэ” (нарны зай)	14.30 Наашаа Цаашаа
18.00	18.10 Төсөөлөөгүй Түвд орон	18.00 “Бизнесийн төв цэг” давталт	18.05 “Бяцхан оцон шувуу Пороро” хүүхэддэйн кино 2.1-6-р анги	18.00 “Тог тог” /season-5/ 2-р хэсэг
20.00	19.40 Шуранхайн нууцад нэвтрэхүй. “Урд л уулын бараа”	20.00 “Made In Mongolia. Гүнгэрваа ХХК” нэвтрүүлэг	20.45 “3 найз. Эргэж ирсэн нь” кино бүтсэн түүх	20.00 Оргил цаг мэдээллийн хөтөлбөр
22.00	22.05 “Далд ертөнц” уран сайхны киноны 3,4-р анги	22.00 “МУ-ын анхны хиймэл дагуул- Мазаалай”	21.50 Дэлхийн санхүүгийн түүхүүд	22.30 “Тэрслүү хөвгүүд” ОАК / season-6/ 9-р анги

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



БОСООГООР:

1. Анхдагчдын өлгий гэгддэг аймаг
2. Монголын нэг ястан
3. “Хэцүү анги” ОАУС киноны хэцүү захирлын дүрийг бүтээсэн жүжигчин
4. Зүрчид, Тунгус угсааны олон аймгийг нэгтгэн Умард Алтай улсыг байгуулсан Манжийн анхны хаан
5. Зүүн аймаг дахь нефтийн арвин нөөц бүхий орд
6. Нэгэн зуулийн хун
14. Улс төрийн байгуулал
15. Хонзон
16. Ариун цэврийн хэрэглэгч Хөндлөнгөөр:
1. Далайн чанадад улаан арьстнуудад хядуулсан зэрлэг үхэр
4. Газар орон
7. Сагсан бөмбөгийн эх

орон (товчилсон нэр)

8. Зөвлөлт Монголчун сансрын (1981 он) II багийн гишүүн
9. Ардчилсан хувьсгалын үед коммунист дарангуйлагчаа эхнэртэй нь гудамжинд буудаж хөнөөсөн улс
10. Эрхтэн

11. Түрэгүүдийн өвөг

12. Алдарт детектив зохиолчийн нэр ... Кристи гишүүн
13. Гөрөөнд сургасан нохой, шувуу зэрэг амьтны мэргэжил
17. Одоогийн Ерөнхийлөгчийн залуудаа дэлхийн аварга болж байсан бөхийн төрөл

Өмнөх дугаарын хариу /09.18



ЗГМ: СҮДОКУ


	4	1	2		9		
				9	4		8
8	6			5			7
		6					4
	5					3	
4				7			
6		1			8	3	
5	2		8				
		4		9	2	7	

9	5	3	6	7	8	4	2	1
2	6	7	4	9	1	8	3	5
8	1	4	3	2	5	7	9	6
5	8	2	9	4	3	6	1	7
4	3	6	8	1	7	9	5	2
1	7	9	2	5	6	3	8	4
3	9	1	7	6	2	5	4	8
6	2	8	5	3	4	1	7	9
7	4	5	1	8	9	2	6	3

(Өмнөх дугаарын хариу)

ЦАГ АГААР

УЛААНБААТАР	ИХ.19	ИХ.20	ИХ.21	ИХ.22	ИХ.23
	21° 4°	23° 8°	8° 7°	12° -2°	16° 3°
Багавтар үүлтэй	7 м/с 5 м/с	10 м/с 6 м/с	12 м/с 10 м/с	8 м/с 8 м/с	8 м/с 6 м/с
		Үүлшинэ	Хур тунадастай	Үүл багасна	Үүлшинэ



[ЗГМ]

“ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ”
СОНИНЫ ОНЛАЙН ЗАХИАЛГА
ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА.

“ZGM-FINANCIAL TIMES”
ДЭЛХИЙН ХЭВЛЭЛИЙГ НЭГ ДОРООС
ЗАХИАЛГЫН ҮНЭ УЛИРАЛД
5000 ТӨГРӨГ

99903581, 70103131

УНШИГЧ ТА МАНАЙ
СОНИНЫ НИЙТЛЭЛ, МЭДЭЭ,
СУРВАЛЖЛАГАТАЙ
ХОЛБООТой САНАЛ
ХҮСЭЛТЭЭ

OPED@ZASAG.CO

ХАЯГААР ИРҮҮЛНЭ ҮҮ.

ЗГМ: КОМИКС



Mr. Баагийгийн Бодрол



Чамайг аа ямар
их санав аа,
ирэхгүй нь гэж л
бодлоо.

NOMADIC
COMICS
[ЗАСГИЙН ГАЗРЫН
МЭДЭЭ]

ОНЦЛОХ ҮЗВЭР

Музейд загварын шоу болно



Цагаан, ногоон дарь эх бүтээлээс сэдэвлэн урласан хувцас загварын “Тара” шоу Г.Занабазарын нэрэмжит Дүрслэх урлагийн музейд олны нүдийг хужирлах гэж байна. Эмэгтэй хүний төгс нандин сэтгэлийг биеийн гоо сайхантай уялдуулж, орчин цагийн өнгө аястай хослуулсан тэдгээр бүтээлийг урлахдаа дизайнер Б.Энхбаатар урлажээ. Тэрбээр “Өндөр гэгээн Г.Занабазарын ертөнцөөс хэтийсэн үнэмлэхүй гоо сайхныг төгс илэрхийлэгч лагшин дүрийн шүтээн Цагаан дарь эх, Ногоон дарь эх бүтээлээс сэдэв, санаагаа олсон” гэж тодотголоо. Есдүгээр сарын 25-нд болох энэхүү шоууд шилдэг загвар өмсөгч, зарим уран бүтээлчид оролцох аж. Дүрслэх урлагийн музейн тансаг, нууцлаг орчинд загварын шоу болж байсан удаагүй. [ЗГМ]

ҮЗВЭР



“Шинэ үе” продакшны “Төгс нөхрийн эрэлд” инээдмийн шоу тоглолт өдөр бүр 19.00 цагаас болж байна. Тасалбарын үнэ 13 мянган төгрөг.



Үндэсний язгуур урлаг орчин үеийн урлагтай хэрхэн төгс хосолж буйг харуулсан “Намар” шоу тоглолт энэ сарын 22-ны 19.00 цагт болно. Хамгийн сүүлийн үеийн техникээр тоноглогдсон концертын танхимд гэрэл, дуу дүрсний онцгой шийдлийг харуулна гэдгээ зохион байгуулагчид амлаж байна. Тасалбарын үнэ 60 мянган төгрөг бөгөөд үүнд оройн хүлээн авалтын үнэ багтжээ.



Ж.Вердигийн “Аида” дуурийг аравдугаар сарын 7, 8-нд театрын тайзнаа үзэгчдийн хүртээл болгоно. Нийт 180 минут үргэлжлэх энэхүү дуурийн тасалбарын үнэ суудлаасаа хамаараад 10-30 мянган төгрөг. Ж.Верди 1871 онд Египетийн хааны хүсэлтээр энэхүү дууриа бичсэн бөгөөд 2011 онд УДБЭТ-ын тайзнаа анх толилуулж байв.



Есдүгээр сарын 26-нд болох Идэрээгийн тусгай тоглолтын тасалбар 30 цагийн дотор зарагдаж дуусчээ. Тасалбар авч амжаагүй олон хүн үлдсэн тул 27-ны өдөр тусгай тоглолт хийхээр болсон байна. Тоглолт 27-ны лхагва гарагийн 20.00 цагаас UB Comedy клубийн тайзнаа болно. Тасалбарын үнэ 20 мянган төгрөг.

ЗУРХАЙ



Билгийн тооллын 29

Намрын тэргүүн шар бич сарын нэг цагаан мэнгээтэй шаргагчин тахиа өдөр.

Үс засуулбал: Сүлд тэнэж ордо

Наран ургах, шингэх: 06.37-18.54

Барилдлага: Арвидых

Шүтэн барилдлага: Хүрэлцэхүй

Суудал: Шороо

Аргын тооллын есдүгээр сарын 19, Ангаргаг гараг. Билгийн тооллын 29, Бага мөр одтой, шаргагчин тахиа өдөр.

Өдрийн наран 06.37 цагт мандаж, 18.54 цагт жаргана. Тухайн өдөр үхэр, могой жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, хүү сангийн эх хатгах, эд агуур авах, зээл авах, арвижуулах, дэлгэрүүлэх үйл эхлэх, хагалгаа хийлгэх, буг дарах, газрын ам бооход сайн. Мод суулгах, нарийн чанд зөвлөгөөн хийх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргэлжлэх буюу засуулахад тохиромжгүй.



УБ-Москва	15.50	14.28
Москва-УБ	21.35	07.30
УБ-Эрхүү	21.10	02.40
Эрхүү-УБ	15.35	06.20
Замын-Үүд-УБ	17.35	08.55
УБ-Замын-Үүд	17.20	07.05
УБ-Сүхбаатар	21.15	05.12
Сүхбаатар-УБ	20.55	05.03
УБ-Эрдэнэт	20.30	07.45
Эрдэнэт-УБ	19.10	05.48
УБ-Зүүнхараа	17.30	21.45
Зүүнхараа-УБ	04.25	08.40



УБ-Бээжин	17.55	20.10
Бээжин-УБ	21.10	23.40
УБ-Хонконг	06.25	10.55
Хонконг-УБ	12.05	16.45
Бишкек-УБ	04.15	10.05
УБ-Бишкек	11.05	13.30
УБ-Сөүл	00.00	03.20
Сөүл-УБ	19.15	21.50
Москва-УБ	00.00	06.00
УБ-Москва	07.10	08.45
УБ-Тяньжинь	14.15	17.15
Тяньжинь-УБ	18.15	21.15

АНУ Парисын уур амьсгалын гэрээнд үлдэнэ

Трампын засаг захиргаа зохих нөхцөлд Парисын уур амьсгалын гэрээнд үлдэхээр бэлтгэж байгаа аж. > 10

Хятадын хойд солонгосчууд гадаад ертөнцийн гүүр болдог

Хятадын хил дээрх солонгос зоогийн газарт ажилладаг залуу "Сайн найзуудтайгаа сайхан байсан даа" хэмээн сүүрс алдав. > 10

Хөрөнгийн бирж дуулианаас салсангүй

Үүссэн дуулианыг ил тод шийдээгүй нь биржийг хэвийн ажиллуулах хугацааг хойшлууллаа гэж удирдлага нь мэдэгдлээ. > 10

Дизель автомашин бодож байснаас ч бохир

Патрик МакГи

Хамгийн орчин үеийн дизель хөдөлгүүртэй автомашин хүртэл та бидний урьд нь төсөөлж байснаас хавьгүй "бохир" болохыг шинэ судалгаагаар илрүүлээ. Уг судалгаа нь дизель хөдөлгүүрийг бензин хөдөлгүүрээс илүүд үзээр байгаа Европын зарим зохицуулах байгууллагад хүнд асуулт болов.

Ердийн дизель хөдөлгүүртэй автомашин нийт ашиглалтынхаа турш 42.65 тонн нүүрстөрөгчийн давхар исэл ялгаруулдаг нь бензин хөдөлгүүрт машинаасаас 3.65 тонноор их байгааг Брюссельд байрладаг Transport & Environment (T&E) байгууллага тооцоолжээ.

"Автомашин үйлдвэрлэгчдээс дизель автомашиныг уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх зорилгод нийцүүлэн сайжруулах мэдэгдлийг энэ судалгаа утгагүй болголоо. Дизель автомашин нь азотын давхар исэл, бичил тоосонцор зэрэг хорт бодисын хэмжээгээрээ төдийгүй нүүрстөрөгчийн давхар ислийн хэмжээгээрээ ч бензин машинаас их байна. Зардал нь хүртэл бензин хөдөлгүүртэй машинаас дунджаар 2000-3000 еврогоор их гарлаа" хэмээн тус байгууллага мэдэгдэв.

Хоёр жилийн өмнө АНУ-ын зохицуулах байгууллагууд Volkswagen-ийг дизель хөдөл-



BBM©

гүүрийн 10 жилийн луйврын хэрэгт буруутгасан. Тэр цагаас хойш Европын орнуудад дизель хөдөлгүүртэй автомашины борлуулалт тогтмол буурч байна. Дуулиант хэрэгтэй уялдан автомашинаас хүрээлэн буй орчинд ялгаруулж буй хорт ялгарлын статистик эргэлзээтэй болж, Европын олон хот ойрын ирээдүйд дизель хөдөлгүүрийг хориглох судалгаа явуулж эхлэв. Таагүй нөлөөнөөс шалтгаалан эдүгээ 50 хувьтай байгаа Европын холбоонд бүртгэлтэй дизель автомашины тоо 2020 он гэхэд гуч гаруй хувь

хүртлээ буурах тооцоог JPMorgan гаргажээ.

Гэтэл автомашин үйлдвэрлэгч компаниуд "цэвэр" дизель хөдөлгүүрийн төлөө тэмцээр л байна. "Шинэ үеийн дизель хөдөлгүүртэй автомашин нь уур амьсгалын өөрчлөлтийг зогсоох ойрын ирээдүйн зорилгод нийцэж байгаа. Учир нь ийм машин бензин хөдөлгүүртэй загвараас 15-20 хувиар бага нүүрстөрөгчийн давхар исэл ялгаруулдаг" хэмээн Daimler-ийн ерөнхий захирал, Европын автомашин үйлдвэрлэгчдийн холбооны ерөнхийлөгч Дитер

Цетше өнгөрсөн долоо хоногт мэдэгдлээ.

Гэтэл зохицуулах байгууллагууд автомашины зөвхөн яндангаас ялгардаг утааг богино хугацаанд хэмжих аргаар тооцоолж буй нь дизель хөдөлгүүр нүүрстөрөгчийн давхар исэл бага ялгаруулдаг гэсэн дүгнэлт гаргах үндэс болсныг T&E тайлбарлав. Үүний оронд автомашины ашиглалтын бүхий л мөчлөг буюу үйлдвэрлэлд шаардлагатай шатахуун, материалын эх сурвалж, тухайн машины хэрэглээ, бүрдэлд багтаж буй эд ангийн дахин ашиглалт зэр-

гийг хамруулсан цогц тооцоо хийх ёстойг тус байгууллага анхааруулсан юм.

Дизель хөдөлгүүртэй автомашин бензин хөдөлгүүр бүхий ижил загвараасаа илүү "бохир" гэсэн дүгнэлтийг үндсэн гурван шалтгаанд тулгуурлан гаргажээ. Үүнд нэгдүгээрт, дизель түлшийг илүү нарийн нэрэх аргаар гаргаж авдаг. Хоёрдугаарт, дизель түлш бензинээс өндөр хэмд шатдаг учраас хөдөлгүүрийн эд анги илүү бөх, тэсвэртэй байх шаардлагатай. Гуравдугаарт, дизель түлш үнэ хямд учраас дизель автомашины гүйлт илүү их.

Дизель хөдөлгүүрийн ялгарал их ноцтой биш байж болно. Гэтэл сүүлийн 10 жилд бензин хөдөлгүүрээс ялгардаг хорт бодисын хэмжээ эрс буурсан нь дизель хөдөлгүүрийн давуу талыг үгүй хийж байгааг уг судалгааг хийсэн гол хүн, T&E-ийн "цэвэр" автомашин, агаарын чанар хариуцсан менежер Жулия Полисканова тайлбарлав.

"Дизель хөдөлгүүр 1990-ээд онд ухаалаг сонголт байсан байх. Одоо бол үгүй. Ийм хөдөлгүүрт ирээдүй байхгүй. Цаашид гибрид юм уу цахилгаан хөдөлгүүр л зөв шийдэл" хэмээн тэрбээр өгүүлж байна.

Тус байгууллагын судалгаагаар

өнгөрсөн долоо хоногийн эцсээр танилцсан BMW, Daimler компани шууд хариу өгсөнгүй. Урьд нь хийж байсан хэд хэдэн туршилтаар дизель автомашины нийт ашиглалтынхаа хугацаанд бензин хөдөлгүүртэй машинаас нүүрстөрөгчийн давхар исэл бага ялгаруулдаг нь тодорхой болсон гэж Volkswagen хариу өгч байна.

"Манай судалгаагаар ижил үзүүлэлттэй, эдэлгээний хувьд төстэй дизель, бензин хөдөлгүүртэй автомашиныг харьцуулах тохиолдолд эхнийх нь нүүрстөрөгчийн давхар исэл бага ялгаруулдаг гэсэн дүгнэлт гарсан" хэмээн тус компани мэдэгдлээ.

Дизель хөдөлгүүртэй хамаатай хэргийн гол буруу нь автомашин үйлдвэрлэгч компаниудад бус, "тажгуудсан зохицуулалт, татвар"-т байгааг Европын 26 улсын 50 байгууллагыг төлөөлдөг T&E тайлбарласан юм.

Европын улсуудад дизель түлшний татвар бензинийхээс мэдэгдэхүйц бага, шатахуун түгээх станцууд дээр 10-40 хувийн хямд байдаг. Европын холбоонд ганц Их Британи "дизелийн урамшуулал"-гүй байсан бол саяхан Франц, Бельги хоёр ялгаатай түлшний татварын зөрүүг багасгах амлалт хийлээ.

Хүнд, овор ихтэй тээврийн хэрэгслийн хэрэглээг дэмжсэн тогтолцоог зогсоож, нүүрстөрөгчийн ялгарлын үнэн бодит хэмжээнд суурилах замаар "шатахуун, автомашины татвар хоёрыг шуударга болгох"-ыг T&E уриалж байна. XX зуунтай үлдэх ёстой технологид мөнгө, эрч хүчээ зориулахаа Европ тив зогсоох цаг боллоо" хэмээн тус байгууллагын тайланд бичжээ.



Бангладеш рохинжа нарын хөдөлгөөнийг хязгаарлав

Киран Стэйси

Дүрвэгсдийн хямралд нэрвэгдсэн Бангладеш улс Мьянмараас дүрвэн тус улсад цутгаж буй мусульман рохинжа нарын шилжих хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээ авч эхэллээ.

Тоо нь сүүлийн гуравхан долоо хоногт 400 мянгыг даваад буй дүрвэсэн хүмүүсийг хуаран байрлаж буй Кокс базарын бүсээс гадагш гарахыг хориглосон талаар Бангладешийн цагдаагийн газар ням гарагт мэдэгдлээ.

Үүний зэрэгцээ дүрвэсэн хүмүүст зориулсан шинэ том хуаран байгуулахаар Бангладешийн эрх баригчид төлөвлөж байна. Мьянмарын өрнөд хэсгийн Рахин мужид дэгдсэн хүчирхийллээс дүрвэж тус улсад ирсэн олон мянган хүн замын хажууд унтаж, саравчинд хоргодсон хэвээр.



Бангладешийн Кокс базар дахь рохинжа дүрвэгсэд

BBM©

"Эх орондоо буцах хүртлээ энэ хүмүүс зааж өгсөн хуаранд байрлах ёстой. Хүмүүс машин

болон төмөр зам, далайгаар нэг газраас нөгөөд шилжихийг хориглож байна" хэмээн

Бангладешийн цагдаагийн газар мэдэгдлээ. Анд нөхөр, гэр бүлийн гишүүн байлаа ч

рохинжа дүрвэгчийг орон гэртээ байлгаж болохгүй гэсэн зааврыг цагдаагийн газраас нутгийн оршин суугчдад өгчээ.

Өнгөрсөн сараас Бангладешийн хил даван бөөнөөр дүрвэж эхэлсэн рохинжа нар тус улсад хүнд сорилт боллоо. "Аракань рохинжа нарыг чөлөөлөх арми" нэртэй зэвсэгт бүлэглэл наймдугаар сарын 25-нд Рахин мужийн цагдаагийн 30 цэг, армийн байрлал руу довтолж, хэд хэдэн хүн хөнөөсний дараахан Бангладешид хүчирхийлэл дахин дэгдсэн юм.

Мьянмарын зэвсэгт хүчнээс хэрэгжүүлсэн залхаан цээрлүүлэх харгис ажиллагаанаас болж хүмүүс орон гэрээсээ дайжихад хүрсэн талаар дүрвэсэн рохинжа нар тайлбарлав. НҮБ-аас "үндэстнээр нь цэвэрлэх ажиллагааны жишээ"

хэмээн тайлбарласан залхаан цээрлүүлэлтээс болж Мьянмарын де факто удирдагч, Нобелийн шагналт Аун Сан Су Чи олон улсын зүгээс шүүмжлэл хүлээсэн.

Бангладешийн хилийн харуулууд тус улсад нэвтэрч буй дүрвэгсдийг анх хориглон тогтоож гэж оролдсон ч хүмүүсийн тоо хэт ихэссэнээс шалтгаалан бүтэлгүй болдоогоо орхиход хүрчээ. Мьянмараас дүрвэгсдийг хоёр улсын хилийн ойролцоо оршдог, Бангладешийн далайн эргийн Кокс базар хэмээх газарт бөөнөөр нь байлгахуар оролдож байна.

НҮБ-аас наймдугаар сарын 25-нд гаргасан сүүлийн тооцоогоор Мьянмараас Бангладеш рүү 409 мянган хүн шинээр нэвтэрчээ. Гэтэл энэ тоонд урьд өмнийн хүчирхийллээс зугтаан тус улсад орогнож буй 400 мянган рохинжа багтаагүй.

Шинээр ирэгсэд хот, хөдөөд өөрсдөдөө зориулан оромж байгуулж буй талаар тусламжийн байгууллагууд тайлбарлав. Мөн орон нутгийн зургаан иргэнийг дүрвэгсдэд газар, оромж олгосон хэргээр баривчилжээ.

Дүрвэгсдийн дунд хоол тэжээлийн хомсдол нүүрлэж, халдварт өвчин тархах аюул тулгарсан тул Бангладешийн удирдлага одоогийн Кутупалон хуарангийн ойролцоо 810 га талбайд 14 мянган оромж бүхий шинэ хуаран байгуулахаар амлаад байна. Нэг оромжид зургаан хүн багтаах тус хуаранг арав хоногт багтаан байгуулж дуусгахуар төлөвлөсөн талаар эрх баригчид тайлбарлав.

Шинээр ирэгсэд бие засах газар олдохгүй байгаа нь Кокс базар дахь хуаранд тулгарч буй гол бэрхшээлийн нэг. Бангладешийн эрүүл мэндийн яам 500, НҮБ-ын дүрвэгсдийн агентлаг дахиад 800 тур бие засах газрыг хуаранд байгуулах гэж буй талаар тус яамны төлөөлөгч мэдэгдлээ.



WTI фьючерс Brent-ийг гүйцлээ

Грегори Майер

АНУ-ын газрын тосны фьючерсын зах зээл хэмжээгээрээ дэлхийд тэргүүлж буйгаа тунхагласан нь занарын эрчим хүч үйлдвэрлэгч нар үнэ уналтын дараа хөл дээрээ боссоньг нотлов.

West Texas Intermediate (WTI) түүхий газрын тосны фьючерсын гэрээний нээлттэй позицитай тоо 2.4 саяд хүрсэн нь Лондон дахь Brent түүхий газрын тосны зах зээлийн амжилтыг 2014 оноос хойш анх удаа эвдэж буй хэрэг боллоо. Арилжаа нь энэ онд 16 хувиар өссөн WTI-ийн фьючерсын гэрээний нийт тоо өнгөрсөн долоо хоногт шинэ амжилт тогтоосон юм.


Газрын тосны үнэ баррель нь бараг 50 ам.долларт хүрч тогтворжиж эхэлсний ачаар өрөмдөгч нар АНУ-ын ордуудад ажилдаа эргэн орцгоосон нь Нью-Йоркийн WTI фьючерсийн зах зээлийг

өргөжихөд хүргэлээ.

Занарын тос олборлогч нар дахин үнэ унах үед баталгаатай байх үүднээс WTI гэрээ сонгох нь илүү байгаа. Учир нь Пермийн галавын болон бусад үеийн занар агуулдаг бүсээс гаралтай газрын тосны үнэ Умард тэнгисээс олборлодог Brent-д бус, WTI-д түшиглэх нь их байдаг.

"АНУ-д олборлолт сайжрах хэрээр арилжаач нарт Умард Америкийн, ялангуяа Техасын түүхий газрын тостой холбоотой эрсдэл ихсэж байгаа"-г Нью-Йоркийн таваарын биржид WTI гэрээний арилжаа голлон эрхэлдэг CME Гроуп-ийн гүйцэтгэх захирал Питер Киви тайлбарлав.

Жилийн өмнө өдөрт 8.55 сая баррель олборлож байсан АНУ-ын түүхий газрын тосны үйлдвэрлэл энэ сарын байдлаар есөн хувиар өсөж, өдөрт 9.29 сая баррель болсон талаар АНУ-ын эрчим



хүчний мэдээллийн удирдах газар мэдээллээ. Техас, Нью Мексико муж улс дахь Пермийн галавын үеийн баялаг сав газарт олборлолт нэгдүгээртэй захирал WTI гэрээний арилжаа голлон эрхэлдэг CME Гроуп-ийн гүйцэтгэх захирал Питер Киви тайлбарлав.

Жилийн өмнө өдөрт 8.55 сая баррель олборлож байсан АНУ-ын түүхий газрын тосны үйлдвэрлэл энэ сарын байдлаар есөн хувиар өсөж, өдөрт 9.29 сая баррель болсон талаар АНУ-ын эрчим

фьючерсын арилжаа хийж буй компаниудын талаар илүү зөв ойлголт өгөх хэрэглүүр болдог. Нээлттэй позиц нь "Жинхэнэ арилжааны оролцоо байгаа эсэхийг харуулдаг түлхүүр үзүүлэлт" хэмээн Intercontinental Exchange-ийн гүйцэтгэх захирал Жеффри Шпрехер тайлбарлав.

Бие даасан олборлогч компаниуд Уолл Стрийтийн банкуудтай тохиролцох замаар своп гэрээ байгуулж фьючерсийн бирж дээр тохиолдож болзошгүй эрсдлээс сэргийлдэг.

Своп дилерүүдийн дундад WTI-гийн богино позицитай тоо 2017 онд 37 хувиар өсөж, 450 мянган гэрээ болсныг Таваарын фьючерсын арилжааны комиссоос баасан гарагт нийтэлсэн тайланд дурджээ. Ийм нэг гэрээ 1000 баррель газрын тос нийлүүлэх нөхцөлтэй.

Дэлхийн түүхийн газрын тосны анхны фьючерс гэрээ болж хувирсан WTI нь 1983 онд үүссэн юм. Хожим дэлхийн зах зээлийнхтэй харьцуулсан АНУ-ын үнэ унаснаас шалтгаалан сүүлийн арван жилд WTI-ийн гол өрсөлдөгч нь Brent болж хувирчээ. WTI-ийн нээлттэй позицитай тоо 2014 оны эцсээс хойш Brent-ийнхээс цөөрсөн.





BBM©

АНУ Парисын уур амьсгалын гэрээнд үлдэнэ

Рошель Топленски, Кортни Вивер

АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Рекс Тиллерсон ням гарагт Трампын засаг захиргаа зохих нөхцөлд Парисын уур амьсгалын гэрээнд үлдэхээр бэлтгэж байгааг мэдэгдэв. Түүний хэлснээр Ерөнхийлөгч тэдгээр нөхцөлийг тодорхойлохоор зөвлөлдөж буй боловч яг ямар тохиролцоонд хүрэх нь тодорхойгүй хэвээр байгаа аж. Ноён Тиллерсон CBS телевизийн “Үндэстний өмнө” нэвтрүүлэгт оролцох үед дээрх санааг хэлсэн нь Вашингтоны байр суурь эрс өөрчлөгдсөнийг харууллаа.

Монреальд болсон Байгаль орчны сайд нарын олон улсын уулзалтад оролцсон АНУ-ын төлөөлөгчид тус улсын нүүрс-хүчлийн хий ялгаруулах квотыг багасгаж уур амьсгалын гэрээнд үлдэж магадгүй хэмээн ярьсан нь Вашингтон энэ асуудлаар

байр сууриа зөөллөх байх гэсэн хүлээлт үүсгээд байсан юм. Цагаан ордон дээрх яриаг үгүйсгэж байгаа ч Монреалийн уулзалтад оролцогчид Америк улс гэрээг бүрэн татгалзалгүй, хүлээсэн үүргээ эргэн харах болов уу гэсэн ойлголттой үлдсэн байна.

Европын холбооны уур амьсгалын асуудал эрхэлсэн комиссар Мигель Канете “АНУ-ын тал Парисын гэрээг үндсээр нь өөрчлөх хэлэлцээр хийхгүй, харин уг гэрээнд оролцох нөхцөлөө эргэн харахыг оролдно” гэжээ. Цагаан ордны үндэстний аюулгүй байдлын зөвлөх АКМастер “Ноён Трамп хэрвээ АНУ-д илүү сайн нөхцөл олговол тодорхой хугацааны дараа гэрээнд эргэн нэгдэх үүд хаалгыг нээлттэй үлдээсэн” хэмээн тайлбарлав.

Зургадугаар сард АНУ-ын Ерөнхийлөгч тус улс Парисын

гэрээнээс гарна гэж мэдэгдсэн билээ. Уг гэрээгээр дэлхийн температурын өсөлтийг аж үйлдвэржихээс өмнөх түвшинтэй харьцуулахад хоёроос доогуур хувьд хадгалж зорилт тавьсан юм. Тухайн үед ноён Трамп “АНУ Парисын гэрээг бүхэлд нь шинэчилж, эргэн нэгдэх хэлэлцээ хийж эхлэхэд бэлэн байна. Нөхцөл нь АНУ-ын хувьд шударга, түүний бизнес, ард иргэд, ажилчид, татвар төлөгчдөд шударга байх ёстой” хэмээн мэдэгдэж байв.

Вашингтон гэрээнээс гарах өргөдлөө НҮБ-ын уур амьсгалын албанд хүргүүлсэн боловч гэрээний заалт ёсоор 2020 он хүртэл албан ёсоор гарах эрхгүй юм. Монреальд уулзсан сайд нар Германы Бонн хотод арваннэгдүгээр сард болох уур амьсгалын дээд хэмжээний уулзалтын өмнө гэрээг хэрхэн

хэрэгжүүлэх асуудлыг хэлэлцсэн байна. Парисын гэрээнд гарын үсэг зурсан 195 орны төлөөлөгчид Үндэстний тодорхой хувь нэмэр гэдэг санаачилгын хүрээнд улс тус бүр хүлэмжийн хийн ялгаруулалтаа багасгах сайн дурын төлөвлөгөөгөө танилцуулах учиртай.

Гэрээний ерөнхий зорилтын хувьд АНУ-ын оруулах хувь нэмэр маш чухал бөгөөд тус улс хүлэмжийн хийн ялгаруулалтаар Хятадын дараа, дэлхийд хоёрдугаарт бичигддэг. Трампын засаг захиргаа Хятад улсыг хорт хийг багасгах зорилгод илүү ачаалал үзрэх ёстой гэж үзэж байгаа. Ноён Тиллерсон “Парисын уур амьсгалын гэрээний зорилтот түвшин талаас нь харвал дэлхийн хоёр том эдийн засгийн тэнцвэр үнэхээр алдагдсан байна” хэмээн онцолсон юм.

FT

Хөрөнгийн бирж дуулианаас салсангүй

Саймон Мунди

Энэтхэгийн үндэстний хөрөнгийн биржид (ҮХБ) өндөр эргэлтэй арилжаанаас үүссэн дуулианыг ил тод шийдвэрлэж чадаагүй нь тус байгууллагыг хэвийн ажиллагаанд оруулах хугацааг хойшууллаа гэж уявчлалга нь үзэж байна. Энэтхэг арилжааны хэмжээгээр тэргүүлдэг тус биржийн зарим арилжаалагч худалдааны системээс давуу эрх олж авсан гэж шүүмжлэл сүүлийн хоёр жил үргэлжилсэн. Эхэндээ үүнийг нэр төр гутаах гэсэн оролдлого хэмээн няцаасан боловч ҮХБ-ийг Энэтхэгийн хувьцааны зохицуулагчид шалгаж эхэлсэн юм. Үүний улмаас Goldman Sachs, Нью-Йоркийн хөрөнгийн бирж групп, Японы SoftBank зэрэг хувьцаа эзэмшигчид нь хувьцаагаа арилжих төлөвлөгөө хойшлогджээ.

ҮХБ-ийн захирлаар долдугаар сард томилогдсон Викрам Лимайэ “Асуудлыг зохицуулагчидтай сайтар ярилцаж, хамтрах байдлаар ил тод шийдвэрлэсэн бол өнөөгийн түвшинд хүртэл хурцдахгүй байлаа” хэмээн Fi-

хувьцаанаас худалдан авсан гадаадын хөрөнгө оруулагчид арван жилийн өмнөөс уг арга хэмжээг хэрэгжүүлэхийг сануулсаар иржээ.

Бомбейн хөрөнгийн биржийн хувьцааны өртөг нэгдүгээр сард 58.3 тэрбум рупигээр үнэлэгдсэн. ҮХБ-ийн захирлуудын зөвлөл 2016 оны зургадугаар сард хувьцаагаа гаргахын төлөө санал баталсан авч ноён Лимайэ цаг хугацаа нь тодорхойгүй бөгөөд зохицуулагчийн мөрдөн байцаалтаас хамаарч байгааг мэдээлэв.

Тэрбээр “Энэ бол нийт үндэстний ач холбогдолтой байгууллага. Хагас дутуу зохицуулалтаас болж ажиллагаа нь саатах ёсгүй. Асуудал шийдэгдэж, бид урагш алхах нь бүгдийн ашиг сонирхолд нийцнэ” гэжээ. 2015 онд Moneylife хэмээх бизнес мэдээллийн сайтад нэрээ нуусан харилцагчийн захидал нийтлэгдсэний дараа шуугиан дэгдсэн юм. Уг захидалд нэгэн брокер өндөр эргэлтийн арилжааны системд бусад хөрөнгө оруулагчаас өмнө нэвтэрч, өөртөө илүү ашигтай арилжааны хууль бус давуу тал олж авсныг илчилсэн билээ.



BBM©

ncial Times-г яриу. Энэтхэгт анх удаа бүрэн цахимжсан хөрөнгийн бирж болох уг ҮХБ 1994 онд байгуулагдсанаас хойш бэлэн мөнгөний хувьцаа, хоёрдогч үнэт цаас, компанийн фонд зэрэг үйлчилгээний дийлэнх хэсгийг хуучин Бомбейн хөрөнгийн биржээс татан төвлөрүүлсэн юм. Өнгөрсөн санхүүгийн жилд ҮХБ-ийн цэвэр ашиг 12.2 тэрбум рупи (190 сая ам.доллар), орлого нь 26.8 тэрбум рупи байв.

2015 оны арванхоёрдугаар сард Үнэт цаас, биржийн зөвлөл хэмээх Энэтхэгийн зах зээлийн зохицуулагч гол хөрөнгийн биржүүдэд гарах замыг хөнгөвчлөх шийдвэр гаргасан нь өмнөх хатуу журмыг зөвлөрүүлсэн алхам болсон билээ. Тус биржийн

Хөрөнгийн бирж эрс эсэргүүцсэн няцаалт гаргаж, Moneylife-ийг нэр төрд халдлаа хэмээн шүүхэд өгч байв. Гэтэл өнгөрсөн оны сүүлээр гаднын аудитын байгууллага зарим брокерт давуу эрх олгож байсан баримт илрүүлсэн учир буруугаа зөвшөөрч, уг ихэрхүү байр суурь нь дарагдсан юм. Лимайэгийн өмнө захирагч Читра Рамкришна баримт илрэхээс хэдэн долоо хоногийн өмнө хувийн гэх шалтгаанаар огцорсон. Энэ долоо хоногт ҮХБ Moneylife-ийн эсрэг шүүхийн заргаа татсаныг ноён Лимайэ “Ихэрхүү, түрэмгий, үл хамтрах” корпорацийн соёлоос шийдвэртэй татгалзаж буй хэрэг хэмээн тайлбарлажээ.

FT

Хятадын хойд солонгосчууд гадаад ертөнцийн гүүр болдог

Юан Ян

Хойд Солонгосын цагаач Сон Тианиу заримдаа эх орноо санадаг гэнэ. Хятадын хил дээрх Дандон хотын Солонгос зоогийн газруудын нэгэнд ажилладаг хорь гарч буй энэ залуу “Сайн найзуудтайгаа сайхан байсан даа” хэмээн сүүрс алдав. Ноён Сон хятад гаралтай тул хилээр чөлөөтэй орж гарах буюу иргэн болох тусгай эрхтэй цөөн хойд солонгосчуудын нэг юм. Арван хэдтэйгээ Дандонд ирсэн тэрбээр Солонгосын ардын армид 10 жилийн албыг заавал хаах эрчүүдийн үүргээс мултарчээ. Сон гэдэг бол түүний жинхэнэ нэр биш. Тэрбээр өөрийн үеийнхний зөвхөн мөрөөдөж чадах зүйлийг хийсэн юм. Тодруулбал, Ким Жон Уны дэглэмээс зугтаж, Хятадад ажиллаж байгаа нь тэр.

Ноён Сон “Олон хүн, ялангуяа мянганы үеийнхэн Кимд дургүй. Найзуудад маань Хойд Солонгост өөрийгөө хөгжүүлэх боломж байхгүй” хэмээв. Цөмийн хөтөлбөрийн улмаас Хойд Солонгост тавьсан олон улсын хориг чангарахын хамт тус улс улам тусгаарлагдаж, нутгийн хятад гаралтай иргэд буюу хуацяо нар гадаад ертөнцтэй холбох үлдсэн цөөн сувгийн нэг болж байна. Хятад гаралтай хойд солонгосчууд бизнес зуучлалд чухал үүрэг гүйцэтгэж, Хойд



BBM©

Солонгосын гадаад худалдааны бараг гуравны нэгийг эрхэлдгийг судлаачид болон Дандон дахь хятад худалдаачид ярьж байна.

Циньхуа-Карнегийн төвийн судлаач Жао Тон ярихдаа “Худалдааны бусад суваг хаагдсан тул хүмүүс Хойд Солонгосын хуацяо нарт найдах болсон. Тэдний эрэлт өсөн нэмэгдсээр байна” хэмээн тайлбарлав. Судлаачдын тооцоогоор Умардад 10-15 мянган Хятад гаралтай

иргэд амьдардаг агаад ихэнх нь Хятад руу цагаачлан гарсан тул цөөрсөөр байгаа аж. Бүр 1940-өөд онд БНАСАУ байгуулагдах үед хийгдсэн гэрээний дагуу тэдэнд тусгай статус олгосон байдаг. Лидсийн их сургуулийн Хятадын түүхийн багш Адам Каткарт “Тэд бол социалист интернационализмын амьд үлдсэн сүүлийн гэрчүүд. Тэд үргэлж бие даасан эрхтэй байсан бөгөөд заримдаа систем дотор, заримдаа гадна

оршдог” хэмээн өгүүлэв.

Каткартын ярьснаар ноён Кимийн үед тэдний эрх чөлөө нэмэгдэж, хоёр орны хооронд худалдаа эрхлэх боломж өргөжсөн ба жишээ нь, гэртээ олон улсын ярианы эрхтэй утас тавиулах гэх мэт Хойд Солонгост ховорхон хөнгөлөлт эдлэх болсон байна. 2009 онд Хятадын Ерөнхий сайд Вэн Жиабяо энд айлчилснаас хойш Бээжин бизнест зуучлах тэдний

үүрэг оролцоог илүү үнэлж эхэлсэн аж. Бусад иргэн хилээр гарахад төрөөс зөвшөөрөл авдаг бол хуацяо нар дураараа Хятад руу нэвтрэх эрхтэй.

1990-ээд оноос заримд нь “гол гатлах зөвшөөрөл” олгогдсон нь Дандоныг Хойд Солонгосын хилийн цаадах Синуиру мужаас заагласан Ялу голыг хэлсэн хэрэг юм. Одоо зарим хуацяо Хятадын гадаад оршин суугчийн паспорт авсан агаад үүнийг Хятадын мужуудын хооронд аялахад ашиглаж болно. Хятад дотор хуацяо нар бусад хойд солонгосчуудаас ялгардаг. Умардын ачааны машины жолооч нар цуглардаг зоогийн газарт ирсэн хүмүүс энэртээ хил давагсдын заавал зүүх ёстой Ким Ир Сен эсвэл Ким Жон Уны зурагтай улаан тэмдэг хатгасан байдаг бол ноён Соны гэр бүлийнхэн тийм тэмдэг зүүдэггүй. Олон хүн утсаар ярьж байгаа харагдавч зөвхөн Сон ухаалаг утастай агаад Пхеньянаас гадагшаа интернет сүлжээ бараг барьдаггүй.

Ноён Сон Хойд Солонгос дахь сургуулийн андуудтайгаа голдуу утсаар ярина. Тэд Хятадаас сим карт нууцаар оруулах буюу ямар гутал, хувцас авахаа захиална. Тэрбээр “Хойд Солонгост Хятадын бараа их худалддаг тул шошгыг нь хараад

л надад хэлэхэд болно. Амархан” хэмээн тайлбарлав. Тэр гаалиар дамжуулан илгээмж явуулдаг байна. Соны найзууд цэрэгт татагдаагүй бол голдуу оёдол нэхмэл, цахилгааны үйлдвэрлэлд ажилладаг аж. НҮБ саахан нэхмэлийн бүтээгдэхүүний экспортыг хориглосон учир тэдний боломж хумигдах нь гарцаагүй.

Ноён Соны өвөө эмээ 1940-өөд онд Японы эзлэн түрэмгийллийн дараа Хятадын зүүн нутгийн Шандон мужаас Синуижу руу дүрвэн гарсан юм. Тэр үед Хятадын зарим нутаг Солонгосын хойгоос ядуу байв. Соны үеэл нь ч мөн адил түүхтэй. Түүний өвөө 1950-иад онд Умард Солонгос АНУ-ын эсрэг дайтах үеэр Хятадын сайн дурын армийн бүрэлдэхүүнд багтаж, энд ирсэн гэдэг. Ноён Сон энэ оны сүүлээр Хятадын иргэншил авахаар хүлээж буй агаад эн тэргүүнд жолооны үнэмлэхтэй болж, Хятадын нутгаар тойрон аялах хүсэлтэй гэнэ. Гэвч тэрбээр төрсөн нутгаа санагалздаг нэгэн. Ноён Соноос Хойд Солонгос “сайн улс уу” гэж асуухад хэсэг азнаснаа “Хойд Солонгосыг муу улс гэж ярихаар дургүй хүрдэг. Ерөнхийдөө сайн. Хүмүүс нь сайн” хэмээн өгүүлсэн билээ.

FT

Эдийн засаг

ТӨСӨВ



С.Батсайхан / ЗГМӨ

Төсөөллөөс давсан нэг их наяд

Төсвийн орлого 904 тэрбум төгрөгөөр давж, татварын орлогыг биелжээ

◀1

Ашигт малтмалын ашигдалтын тусгай зөвшөөрөлтэй компаниуд энэ оны эхний долоон сард 900 орчим тэрбум төгрөг татварт төлжээ. Бараг их наяд төгрөг шүргэж буй энэ мөнгө орон нутагт шингэдэг бусад төлбөр, хураамжийг тооцоогүй зөвхөн улсын төсвийг чиглэсэн уурхайн компаниудын татвар. Тэгвэл энэ мөнгө Монгол Улсын нийт татварын орлогын гуравны нэг буюу 30.7 хувийг бүрдүүлжээ. Үүнээс ээс болон нүүрсний ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаниудын төсөвт төлсөн татвар 800 тэрбум төгрөгт хүрлээ.

Ялангуяа, нүүрсний А лицензтэй компаниуд долдугаар сарын байдлаар ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрт 113.8 тэрбум төгрөг төлжээ.

Төсвийн орлого төсөөллийг давснаар алдагдал ч буурлаа. Улсын нэгдсэн төсвийн алдагдал өмнөх оны мөн үеэс 1.2 их наяд төгрөгөөр буурсан гэж статистикийн байгууллага мэдээлэв.

Төсвийн орлого 900-гаад тэрбум төгрөгөөр давж, зарлага 326 тэрбум төгрөгөөр буурсан байна. Энэ хоёр хүчин зүйлс төсвийн алдагдлыг бууруулж, 577 тэрбум төгрөгт хүргэжээ.

● **Татварын орлого 763 тэрбум төгрөгөөр өссөн. Энэ өсөлт төсвийн орлогод түлхэц болжээ.**

● **Төсвийн орлогын эерэг үзүүлэлт зөвхөн алдагдал бууруулаад зогсохгүй тооцолж байсан өрийн хэмжээг ч бууруулах боломжтой.**

● **Төсвийн орлого дээшлэх тусам зарлага өсгөдөг нийтлэг дутагдал манай бодлого тодорхойлогчдод бий.**

● **Төсвийн зөвлөлийн хууль, эрхзүйн орчин бүрдээгүй.**

Төсвийн зарлага буурч, таван их наяд төгрөгтэй тэнцэхэд эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл өнгөрсөн оны мөн үеийнхээс 362 тэрбум төгрөг буюу 74 хувиар буурсан нь нөлөөлөв. Гэхдээ хүүгийн зардал 188, урсгал зардал 130.5, тэрбум төгрөгөөр өссөн нь анхаарал татах үзүүлэлт.

Төсвийн орлогын эерэг үзүүлэлт зөвхөн алдагдал бууруулаад зогсохгүй тооцолж байсан өрийн хэмжээг ч бууруулах боломжтой. Өөрөөр хэлбэл, Засгийн газрын энэ онд авахаар төлөвлөсөн өр, төлбөрийн төдий чинээ буурна гэсэн үг юм.

Үүнээс гадна Монгол Улс ирэх оны нэгдүгээр сард таван жилийн хугацаатай “Чингис” бондын эхний эргэн төлөлт хийх хуваарьтай. Таван жилийн өмнө олон улсын зах зээлээс босгосон 1.5 тэрбум ам.долларын “Чингис” бондын 500 сая ам.долларыг 2018 оны нэгдүгээр сарын 5-нд барагдуулах ёстой. Үүнийг эргэн төлөх эх үүсвэр одоогоор тодорхойгүй байна. Хугацаа нь хоног хоногоор ойртож буй бондын эргэн төлөлт хийхээр Сангийн яам судалгаа хийж буйг албаны эх сурвалж мэдээлсэн. Ойрын хугацаанд олон улсын зах зээлээс шинэ эх үүсвэр татах хүлээлтэй байна.

Ер нь төсөв тойрсон таатай мэдээтэй зэрэгцээд зарим эрсдэл-

Монгол Улсын төсөв

Сүүлийн дөрвөн жилийн наймдугаар сарын байдлаар (Тэрбум төгрөг)

Төсвийн орлого	3,798.0	3,576.5	3,562.4	4,467.2
Төсвийн зарлага	3,951.0	4,345.9	5,371.4	5,044.8
	2014 I-VIII	2015 I-VIII	2016 I-VIII	2017 I-VIII

Үндэсний статистикийн хороо ©

ийг мартаж болохгүй. Төсвийн орлого дээшилснийг далимдуулан зарлага өсгөдөг нийтлэг дутагдал манай бодлого тодорхойлогчдод бий.

Төсвийн орлого ийнхүү таамгаас давахад татвар “тусалжээ”

Өөрөөр хэлбэл, олсныхоо хэрээр зарцуулж, төсвийг үлэмж хэмжээгээр тэлэх хандлага сүүлийн жилүүдэд ажиглагдсан. Тиймээс энэ оны төсвийн тодотгол хэлэлцэхээр хүлээгдэж буй энэ үед төсвийн орлогыг дагаад зарлагыг нь өсгөж магадгүй гэсэн болгоомжлол эдийн засагчдын

дунд бий болчихоод байна. Учир нь их хэмжээгээр тэлсэн төсөв Монголын эдийн засгийн хүндрэлийн нэг шалтгаан болсон гэж шинжээчид тайлбарладаг. Иймд энэ алдаанаас сэргийлэхийн тулд өнгөрсөн оноос эхлэн хумигдаж эхэлсэн төсвийн зарлага, ялангуяа, урсгал зардлыг танах нь чухал юм. Ирэх оны улсын төсвийн төслийг ирэх сарын 1-нээс арваннэгдүгээр сарын 15-ны хооронд батлах хүлээлтэй байгаа. Үүнээс гадна, төсвийн сахилга батыг сахиулж, хяналтын тогтолцоог чамбайруулахын тулд төсвийн зөвлөл байгуулахаар болсон. Одоогоор энэ зөвлөлийн хууль, эрхзүйн орчин хараахан бүрдээгүй байна. Тиймээс ирэх оны төсвийн төслийг өргөн барихдаа эрхзүйн орчныг нь тодорхой болгох шаардлага нэн түрүүнд тулгарч буй. [ЗГМ]

САНХҮҮЖИЛТ

50 сая ам.долларын санхүүжилт татав

Г.Гал
ЗГМ

Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ) Хаан банкинд 50 сая ам.долларын зээл олголоо. Хаан банк энэ санхүүжилтийг харилцагчдадаа

зээл хэлбэрээр олгох аж.

Хувийн хэвшлийг дэмжих зорилготой энэ санхүүжилт нь үндсэн гурван төрлийн зээлээс бүрдэх юм. Тодруулбал, жижиг болон дунд бизнесийг дэмжихэд 27 сая евро зарцуулна. Харин нэмүү өртгийн сүлжээг сайжруулахад 13.5, тогтвортой

эрчим хүчийг санхүүжүүлэхэд 4.5 сая евро хүртэл зээл олгохоор төлөвлөжээ.

ЕСБХБ нь Монгол Улсын хувийн хэвшлийн төсөл, хөтөлбөрүүдэд нийт 1.4 тэрбум орчим еврогийн санхүүжилтийг олгосон хамгийн том олон улсын хөрөнгө оруулагч юм. [ЗГМ]

ТҮҮХИЙ ЭД

БНХАУ-ын нүүрсний олборлолт буурчээ

Б.Ариунболд
Шинжээч

БНХАУ-ын нүүрсний олборлолт хоёрдугаар сараас хойш анх удаа хоёр сар дараалан буурлаа. Ингэснээр тус улсын нүүрсний олборлолт сүүлийн зургаан сарын доод түвшиндээ хүрсэн байна. Учир нь Шаньси дэх нүүрсний уурхайд хэд хэдэн осол гарснаас аюулгүй байдлын хяналтаа чангатгасан. Энэ нь олборлолт буурахад нөлөөлсөн гэж шинжээчид үзэж байна. Наймдугаар сард тус улсын нүүрсний олборлолт сарын дүнгээр 1.2 хувиар буурч, өдөрт 9.38 сая тонн хүрсэн. Гэхдээ жилийн дүнгээр 4.1 хувиар өсчээ.



С.Батсайхан / ЗГМӨ

Өнгөрсөн сард Шаньси мужид байрлах нүүрсний уурхайд зургаан удаа осол гарч, 20 хүн амиа алдсан гэж БНХАУ-ын Төрийн өмчит “China Coal News” агентлаг мэдээлэв. Ийнхүү олборлолт буурсны улмаас тус улсын

нүүрсний импорт наймдугаар сард эрчимжиж, 14 сарын доод цэгээс эргэн сэргэжээ. Харин “China Shen-hua”-гийн нүүрсний борлуулалт наймдугаар сард жилийн дүнгээр 11 хувиар өсөж, 38.2 сая тонн хүрсэн байна.

ДЭД БҮТЭЦ

Ургац тээвэрлэх дөт зам нээлээ

Г.Илч
ЗГМ

Сэлэнгэ мөрний дээгүүр зургаа дахь гүүрийг ашиглалтад орууллаа. Ингэснээр ургац тээвэрлэхээр 120 гаруй км тойрдог байсан замыг дөт болгосон байна.

Булган аймгийн Сэлэнгэ суманд 44 тоннны даацтай, ган төмөр дам нуруу бүхий 437 метр урт төмөрбетон гүүр барилаа. Гүүр

ашиглалтад орсноор ургацын тээвэр саадгүй болохоос гадна бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал ач холбогдолтой албаныхан онцолж байна. “Ингэтийн гүүр” хэмээх энэ гүүрийг дотоодын компани шинэ технологиор барив. Зам, тээврийн хөгжлийн яамны захиалгаар “Хотгор зам” компани гүйцэтгэсэн. Уг замыг Булганаас гадна Сэлэнгэ, Орхон аймгийн иргэд тус гүүрийг ашиглах боломжтой. [ЗГМ]

УУЛ УУРХАЙ

Крэйг Стегмэн ажлаа хүлээлгэн өгнө

Б.Дашням
Шинжээч

“Turquoise Hill Resources” компанийн Захирлуудын зөвлөлийн гишүүн Крэйг Стегмэний ажлаа хүлээлгэн өгөх гэж байна. Компаний мэдээлснээр Крэйг Стегмэн “Rio Tinto”-д шинэ алба хашиж, Австрали руу шилжих болсон тул ийм шийдвэр гаргасан байна. Харин түүний оронд томилох хүнийг тун

удалгүй мэдээлэх аж. “Rio Tinto” металл болон эрдсийн зах зээлд өндөр хүлээлттэй байгааг тус группийн Эрчим хүч, эрдсийн цэгтгэх захирал Жан Себастьян Б.Болд лхагва гарагт Лондонд тавьсан илтгэлдээ онцолжээ.

Түүнчлэн компанийн гүйцэтгэх захирал Жан Себастьян Жак өмнө нь “Б.Болдын удирдаж буй багийнханд ирэх 10-15 жилд эрэлт нь өсөх таваарын судалгаа даалгасан” гэж хэлж байсан юм.

ЗГМ ТОВЧХОН

» МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ

14.5

Их наяд төгрөг. Мөнгөний нийлүүлэлт наймдугаар сарын эцэст 14.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 27.6 хувиар өссөн байна.

» ЗЭЭЛ

13.3

Хувь. Нийт зээлийн өрийн үлдэгдэл тайлант хугацаанд 13.3 их наяд төгрөг болж, жилийн өмнөхөөс 6.6 хувиар нэмэгджээ.

» ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

5.7


Тэрбум төгрөг. Монголын хөрөнгийн бирж өнгөрсөн долоо хоногт нийт 28 тэрбум төгрөгийн арилжаа хийжээ. Өөрөөр хэлбэл, өдөрт дунджаар 5.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

» САНХҮҮ

855.8

Тэрбум төгрөг. Банк бус санхүүгийн салбарын нийт актив 2017 оны хоёрдугаар улиралд 855.8 тэрбум төгрөгт хүрлээ. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 26.5 хувиар буюу 179.3 тэрбум төгрөгөөр өссөн дүн юм.

» АРИЛЖАА



Монголын хөрөнгийн биржийн “MSE ALL” индекс 2.2 хувиар өсөж, 1050.23 нэгжийг давлаа.

» АЖ ҮЙЛДВЭР

3.9

Хувь. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэгчийн үнэ долдугаар сард зургадугаар сарынхаас 3.9, өмнөх оны эцсээс 35.4 хувиар өссөн. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 73.1 хувиар дээшилжээ.

» ТЭЭВЭР

65


Тэрбум төгрөг. Төмөр замын тээврийн орлого энэ оны эхний найман сард 339.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 65 тэрбум төгрөгөөр өслөө. Энэ өсөлтөд өргөн хэрэглээний хүнсний бараа болон хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний тээвэрлэлт нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

ВАЛЮТЫН ХАНШ

Ам.доллар	2465.03
Евро	2938.56
Япон иен	22.27
ОХУ рубль	42.77
БНХАУ юань	376.39
БНСУ вон	2.18

Эдийн засаг

Алтны ханш уналаа



Олон улсын зах зээлд алтны ханш даваа гарагт 0.2 хувиар буурч, унци нь 1317.83 ам.долларт хүрлээ. Энэ сарын эхээр 1340 ам.доллар давтлаа өсөж, сүүлийн гурван жилийн дээд цэгт хүрч байсан шаргал металлын ханш эргэн суларлаа. Ялангуяа, өнгөрсөн долоо хоногийг 0.7 хувийн уналттай үдсэн алтны ханш шинэ долоо хоногт

ч үргэлжлэн уруудав. Алтны ханшид нөлөөлдөг АНУ-ын Холбооны нөөцийн банкны мөнгөний бодлогын зөвлөл энэ долоо хоногт хуралдах товтой. Үүнээс үүдэн алтны ханш хэлбэлзээд байна. Мөн West Texas төрлийн газрын тосны ханш 49.91 ам.долларт хүрлээ. Энэ нь өнгөрсөн долоо хоногоос таван хувиар өндөр дүн. [311]

Microsoft Dynamics NAV ERP системийг Монголд

INTER SOLUTIONS MANAGEMENT LLC
УТАС: +976 76009293
support@ism.mn

МОНГОЛД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛДАГ ГАДААД КОМПАНИУД

НЭР	СИМБОЛ	БИРЖ	ВАЛЮТ	ХАНШ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
RIO TINTO	RIO	ASX	AUD	66.67	▼ -0.21%	9/18/2017
WOLF PETROLEUM	WOF	ASX	AUD	0.019	▼ -13.64%	9/18/2017
PETRO MATAD	MATD	LON	GBX	9.875	▲ +3.95%	9/18/2017
ASPIRE MINING	AKM	ASX	AUD	0.022	▼ -4.55%	9/18/2017
GUILDFORD COAL	GUF	ASX	AUD	0.013	▼ -7.69%	9/18/2017
PROPHECY DEVELOPMENT	PCY	TSX	CAD	3.6	▼ -2.44%	9/18/2017
TURQUOISE HILL RESOURCES	TRQ	TSX	CAD	3.76	▼ -1.05%	9/18/2017
SOUTHGOBI RESOURCES	SGQ	TSX	CAD	0.22	▼ -4.35%	9/18/2017
CANADU MINES	XAM	ASX	AUD	0.21	▲ +5%	9/18/2017
ENTREE GOLD	ETG	TSX	CAD	0.55	▼ -3.51%	9/18/2017

ТҮҮХИЙ ЭД

НЭР	СИМБОЛ	НЭГЖ	ХАНШ (\$)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛТНЫ СПОТ	XAU	унци	1315.4	▼ -0.36%	9/18/2017
ЦАГААН АЛТ	PLA	унци	970.3	▼ -0.15%	9/18/2017
МӨНГӨ	SIA	унци	17.62	▼ -0.46%	9/18/2017
ЗЭС (КОМЕХ)	HGA	фунт	298.05	▲ +1.07%	9/18/2017
ТӨМРИЙН ХҮДЭР	TIOA	тонн	73.5	▼ -0.27%	9/18/2017
WTI ТОС	CLA	баррель	49.99	▲ +0.2%	9/18/2017
БРЕНТ	COA	баррель	55.67	▲ +0.09%	9/18/2017
БЕНЗИН	XBA		166.77	▲ +0.36%	9/18/2017
БАЙГАЛИЙН ХИЙ	NGA	Mmbtu	3.067	▲ +1.42%	9/18/2017
НҮҮРС (NYMEX)	QZA	тонн	336.55	▲ +0.21%	9/18/2017
НҮҮРС (NEW CASTLE)	XWA	тонн	98.1	▼ -0.61%	9/18/2017
ЭЛСЭН ЧИХЭР	SBA	фунт	0.151	▲ +2.15%	9/18/2017
БУДАА	RRA	центнер	12.825	▲ +0.16%	9/18/2017
БУУДАЙ	WA	бушель	449.5	▲ +0.11%	9/18/2017
КАКАО	CCA	тонн	2009	▲ +1.82%	9/18/2017
КОФЕ	KCA	фунт	1.414	▲ +2.72%	9/18/2017

Энэхүү ханшийн мэдээлэл нь хүснэгтэд заасан өдрийн 15 цагийн байдлаарх дүн тул үүнээс хойш өөрчлөгдсөн байх боломжтой.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
АЛУ ХК	APU	606.17	▲ 6.73%	9/18/2017
ГОВЬ ХК	GOV	19630	▼ -0.05%	9/19/2017
МИК ХОЛДИНГ ХК	MIK	11000	▲ 1.85%	9/20/2017
МАХИМПЛЕКС ХК	MMX	2400	◀▶ 0%	9/21/2017
СҮҮ ХК	SUU	160.85	▲ 0.58%	9/22/2017
ТАЛХ ЧИХЭР ХК	TCK	22300	▼ -3.04%	9/23/2017
АДУУН ЧУЛУУ ХК	ADL	2573	◀▶ 0%	9/24/2017
БАГАНУУР ХК	BAN	2313	▲ 6.93%	9/25/2017
МОГОЙН ГОЛ ХК	BDL	5500	▲ 4.76%	9/26/2017
БИ ДИ СЕК ХК	BDS	1175	▲ 2.17%	9/27/2017
УБ-БҮК ХК	BUK	550	▲ 0.92%	9/28/2017
АРИГ ГАЛ ХК	EER	3500	▲ 14.38%	9/29/2017
ХАЙ БИ ОЙЛ ХК	HBO	54.5	▲ 9%	9/30/2017
ХӨХ ГАН ХК	HGN	80.12	▲ 2.72%	10/1/2017
ГЕРМЕС ЦЕНТР ХК	HRM	158	▲ 12.52%	10/2/2017
ЖЕНКО ТУР БҮРО ХК	JTB	54.03	▲ 0.86%	10/3/2017

Тухайн өдөр арилжаалагдсан хувьцаа

ДЭЛХИЙН ГОЛЛОХ ИНДЕКСҮҮД

НЭР	СИМБОЛ	ХАНШ (нэгж)	ӨӨРЧЛӨЛТ	ӨӨРЧЛӨЛТ %	ОГНОО
NASDAQ COMPOSITE	CCMP	6448.467	+19.38	▼ +0.3%	9/18/2017
DAX INDEX	DAX	12518.81	-21.64	▼ -0.17%	9/18/2017
TORONTO STOCK EXCHANGE	SPTSX	15173.03	+0.31	▲ 0.00%	9/18/2017
S&P/ASX 200	AS51	5720.6	+25.58	▼ +0.45%	9/18/2017
S&P 500	INX	2500.23	+4.61	▼ +0.18%	9/18/2017
SHANGHAI COMPOSITE	SHCOMP	3365.748	+12.13	▼ +0.36%	9/18/2017
TOP 20	MSETOP	18229.2	+492.85	▲ +2.78%	9/18/2017
FTSE 100	UKX	7215.47	-79.92	▼ -1.1%	9/18/2017
HANG SENG	HSI	28145.88	+338.29	▲ +1.22%	9/18/2017
NIKKEI 225	NKY	19909.5	+102.06	▲ +0.52%	9/18/2017



TDB PAY ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР ТӨЛБӨР ТӨЛӨХ ЗААВАР

Та өөрийн үйлчлүүлдэг аль ч банкны мобайл аппликейшныг ашиглан дараах 3 алхмын дагуу төлбөрөө төлөх боломжтой.



1 Аппликейшнд нэвтэрнэ.

Өөрийн ашигладаг мобайл банкны аппликейшнд нэвтэрч, QPay цэсийг сонгоно.



2 QR код уншуулна.

QR кодыг утасны камераа ашиглан уншуулснаар төлбөр хүлээн авагчийн овог, нэр, дансны дугаар болон банкны нэр бичих талбаруудад мэдээлэл автоматаар гарч ирнэ. Та төлбөрийн дүнгээ оруулахад л хангалттай.



3 Гүйлгээг баталгаажуулна.

Мэдээллийг шалгаж, гүйлгээний нууц үгээ оруулснаар гүйлгээ баталгаажиж, хүлээн авагчийн дансанд төлбөр шилжиж, орлого орсон талаар мэдэгдэл очно.